

МОНГОЛБАНК (Төв банк)

**Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2015 оны 12 дугаар сарын 31**

МОНГОЛБАНК

2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АГУУЛГА	ХУУДАС
БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1
ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3 - 4
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8 - 9
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	10 – 93

МОНГОЛБАНК

БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛ:

Н.Золжаргал (Монголбанкны Ерөнхийлөгч)
Б.Жавхлан (Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч)
Э.Батшугар (Монголбанкны Дэд ерөнхийлөгч)
Д.Чимэд-Юндэн
(Тамгын газрын захирал)
Х.Дэлгэр
(Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрын захирал)
Д.Болдбаатар
(Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал)
Ж.Батаа
(Валют, эдийн засгийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч)
Д.Ганбат
(Хяналт, шалгалтын газрын захирал)
М.Амгалан
(Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал)
П.Сүхбаатар
(Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газрын захирал)
Г.Эрдэнэбаяр
(Хууль, эрх зүйн газрын захирал)
Д.Довчинбазар
(Мэдээллийн технологийн газрын захирал)
Н.Батсайхан
(Эрсдэлийн удирдлагын албаны захирал)
С.Болд
(Монголбанкны Ерөнхий эдийн засагч)

АЛБАН ХАЯГ:

Монголбанкны байр
Бага тойруу- 3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс

АУДИТОРУУД:

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

МОНГОЛБАНК

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын зөвлөлийн үүрэг байна.

Монголбанкны Захирлуудын зөвлөлийг төлөөлөн Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал би энэхүү тайлангийн 5–93 дугаар хуудсанд үзүүлсэн Банкны санхүүгийн тайлангууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Захирлуудын зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:



Н.ЗОЛЖАРГАЛ
(Монголбанкны Ерөнхийлөгч)

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2016 .04. 21

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Монголбанкны Захирлуудын зөвлөлд

Бид Монголбанкны (“Банк”) 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь удирдлагын хариуцлага байдаг.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа “Аудитын олон улсын стандарт”-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (Үргэлжлэл)

Монголбанкны Захирлуудын зөвлөлд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”-уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн захиалсан аудиттай холбогдуулан Банкны Захирлуудын зөвлөлд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид



ПЕТР МАРКИ
Захирал

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: **2016 .04. 21**

МОНГОЛБАНК

2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Хүүгийн орлого	3	193,582	164,858
Хүүгийн зардал	4	(348,013)	(240,106)
Хүүгийн цэвэр зардал		(154,431)	(75,248)
Алт, үнэт металын арилжааны цэвэр ашиг/ (алдагдал)	5	(1,141)	25,562
Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг/ (алдагдал)	6	37,776	(73,161)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр алдагдал	7	(338,009)	(300,377)
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал	15	(28,603)	–
Үнэт цаас борлуулсны цэвэр ашиг	8	65	103
Үйл ажиллагааны бусад орлого	9	7,492	6,636
Нөөц сангийн буцаалт/ үнэ цэнийн бууралтын (алдагдал)	10	6,396	(81,226)
Захиргааны зардал	11	(21,672)	(21,806)
Үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бусад зардал	12	(9,684)	(15,958)
Нийт алдагдал		(501,811)	(535,475)
Бусад дэлгэрэнгүй орлого			
<i>Дараагийн тайлант хугацаанд орлого үр дүнгийн тайланд дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого</i>			
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн нөөц			
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт		3,211	(271)
- Борлуулах үед орлогын тайланд шилжүүлсэн		(65)	103
		<u>3,146</u>	<u>(168)</u>
Дараагийн тайлант хугацаанд орлого үр дүнгийн тайланд дахин ангилагдах цэвэр бусад дэлгэрэнгүй орлого ба тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		<u>3,146</u>	<u>(168)</u>
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		<u>(498,665)</u>	<u>(535,643)</u>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

**2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө	13	53,793	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	14	1,085,063	1,409,350
Санхүүгийн хөрөнгө оруулалт- Борлуулахад бэлэн	15	2,459,044	1,246,939
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	16	1,328,021	1,466,557
Алт ба үнэт метал	17	420,152	333,959
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	18	8,974	3,264
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших Засгийн газрын үнэт цаас	19	202,218	204,828
Дотоодын банкуудад олгосон зээл	20	1,185,520	2,085,945
Бусад хөрөнгө	21	477,413	658,152
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	22	4,665	450
Үндсэн ба биет бус хөрөнгө	23	28,773	27,390
НИЙТ ХӨРӨНГӨ		7,253,636	7,494,824
ӨР ТӨЛБӨР			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	24	706,656	809,657
Гаргасан үнэт цаас	25	1,024,581	853,781
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	26	702,456	798,649
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	27	1,818,985	2,803,462
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	18	424,995	89,710
Гадаад өр төлбөр	28	3,925,777	2,987,888
Бусад өр төлбөр	29	78,645	81,471
НИЙТ ӨР ТӨЛБӨР		8,682,095	8,424,618
ДҮРМИЙН САН БА НӨӨЦ			
Дүрмийн сан	30	5,000	5,000
Хуримтлагдсан алдагдал		(1,450,237)	(952,809)
Бусад нөөц	31	16,778	18,015
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		(1,428,459)	(929,794)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		7,253,636	7,494,824

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

**2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Тодруулга	Дүрмийн сан сая төгрөг	Хуримтлагд- сан алдагдал сая төгрөг	Бусад сангууд сая төгрөг Тодруулга 31	Нийт сая төгрөг
2014 оны 01 дүгээр сарын 01-нээр	5,000	(424,209)	25,058	(394,151)
Нийт дэлгэрэнгүй орлого	–	(535,475)	(168)	(535,643)
Дахин үнэлгээний буцаалт	–	2	(2)	–
Бусад нөөцөөс хуримтлагдсан алдагдалд шилжүүлсэн	–	6,873	(6,873)	–
2014 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	(952,809)	18,015	(929,794)
Нийт дэлгэрэнгүй орлого	–	(501,811)	3,146	(498,665)
Дахин үнэлгээний буцаалт	–	141	(141)	–
Бусад нөөцөөс хуримтлагдсан алдагдалд шилжүүлсэн	–	4,242	(4,242)	–
2015 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	(1,450,237)	16,778	(1,428,459)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тодруулга	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Тайлант жилийн алдагдал		(501,811)	(535,475)
<i>Тохируулга :</i>			
Алтны дахин үнэлгээний бодит бус алдагдал	5	4,242	6,873
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус алдагдал	6	58,703	370,027
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний бодит бус алдагдал	7	329,575	19,232
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	9	(37)	—
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	12	12	36
Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл	11	2,397	2,476
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал		28,603	—
Үнэ цэнийн бууралтын нөөц сан/(сангийн буцаалт)	10	(6,396)	81,226
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө	11	2,000	3,000
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүр борлуулсны ашиг	8	(65)	(103)
Хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын орлого	9	—	(2,536)
Хүүгийн орлого	3	(193,582)	(164,858)
Хүүгийн зардал	4	348,014	240,106
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		71,654	20,004
<i>Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:</i>			
Алт ба үнэт метал		(90,435)	(53,663)
Урвуу буцаан худалдан авах хэлцэл		139,362	62,658
Дотоодын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж		—	405,000
Дотоодын банкуудад олгосон зээл		(471,470)	(368,296)
Засгийн газрын үнэт цаас		2,683	—
Бусад хөрөнгө		241,209	(171,345)
<i>Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>			
Төв банкны үнэ цаас		170,109	(772,359)
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж		(96,195)	(909,583)
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж		(984,844)	228,679
Бусад өр төлбөр		(2,188)	(12,489)
Үйл ажиллагаанд зарцуулсан хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ		(1,020,115)	(1,571,394)

МОНГОЛБАНК

2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Тодруулга	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хүлээн авсан хүү		187,407	148,974
Төлсөн хүү		(389,945)	(224,322)
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(1,222,653)	(1,646,742)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн болон биет бус хөрөнгийн худалдан авалт	23	(3,975)	(1,793)
Үндсэн хөрөнгө борлуулалтаас хүлээн авсан мөнгө		216	23
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт		(1,086,007)	(1,626,983)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн борлуулалтаас хүлээн авсан мөнгө		1,180,467	2,104,095
Засгийн газрын үнэт цаасны худалдан авалт		–	(207,780)
Хөрөнгө оруулалтаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ		90,701	267,562
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний бууралт		(103,001)	(31,472)
Гадаад өр төлбөрийн эргэн төлөлт		(7,700,355)	(22,507)
Гадаад өр төлбөрийн татан авалт		8,643,221	1,017,417
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		839,865	963,438
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(36,447)	(131,738)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		(328,534)	(547,480)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,466,460	2,013,940
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13	1,137,926	1,466,460

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь Монгол улсын Төв банк (цаашид Банк гэх) бөгөөд Монгол улсын Үндсэн хууль, Төв банкны тухай хууль болон бусад хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Банк нь 1924 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан, Монгол Улс, Улаанбаатар -46, Бага тойруу 3, 15160 хаягт байрладаг.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол улсад явуулдаг ба орон нутагт нийт 17 хэлтэс, салбартай.

Төв банкны тухай хуульд зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах бөгөөд өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн хөгжилд тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх явдал юм.

Банк нь ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болоод хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Төв банкны тухай хуулийн дагуу Банк нь дараах үндсэн үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

- ▶ Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, зохицуулах;
- ▶ Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- ▶ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл “Төрийн”);
- ▶ Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- ▶ Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- ▶ Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах;
- ▶ Бусад банкуудын хувьд үндсэн зээлдүүлэгч байх замаар дахин санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- ▶ Бусад орны Төв банкууд, олон улсын банкууд, бусад хамтран ажилладаг хуулийн байгууллагуудтай Монгол улсыг төлөөлж ажиллах;
- ▶ Хуулинд заасны дагуу бусад санхүүгийн болон зээлийн үйл ажиллагааг явуулах.

Хуулинд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах ба худалдан авах, гадаад валют, үнэт метал худалдах болон худалдан авах, дотоодын болон гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагуудын дансыг Банкинд байршуулах, олон улсын байгууллагуудын дансыг байршуулан шаардлагатай тохиолдолд дэмжин ажиллах үүрэгтэй болно. Монголбанкны дүрмийн санг Монгол улсын төр бүрэн эзэмшдэг.

Банкны 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг Захирлуудын зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрээр зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх барилга байгууламж, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт, үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон алт, үнэт металыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд саятын орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

Нийцлийн мэдэгдэл

Банкны санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэдэг.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас дээш хугацаанд (урт хугацаанд) эргэн төлөгдөх эсвэл барагдуулах төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 36-д толилуулсан болно.

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан толилуулсанчлан орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнахгүй.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БОЛОН ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон доорх СТОУС-уудаас бусад Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил юм.

Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд ба тайлбарууд

- | | |
|---|--|
| • НББОУС 19,
нэмэлт өөрчлөлт | <i>Ажилчдын тэтгэмж – Ажиллагсдын тэтгэмжийн төлөвлөгөө: Ажиллагсдын оруулсан хувь нэмэр¹</i> |
| • СТОУТХ 15 | <i>Үл хөдлөх хөрөнгийн барилгын гэрээ¹</i> |
| • Жил тутмын
сайжруулалтууд
(2010-2012) | <i>2013 оны 12 сард гарсан СТОУС—уудын өөрчлөлтүүд</i> |
| • Жил тутмын
сайжруулалтууд
(2011-2013) | <i>2013 оны 12 сард гарсан СТОУС—уудын өөрчлөлтүүд</i> |

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БОЛОН ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дээрх шинэ болон өөрчлөгдсөн стандартууд ба тайлбаруудыг дагаж мөрдсөнөөр Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд бүртгэлийн бодлогод томоохон өөрчлөлт ороогүй ба ямар нэг нөлөө үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

- СТОУС 9 (2010 оны Санхүүгийн хэрэглүүрүүд³ хувилбар)
- СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 28 нэмэлт өөрчлөлт *Хөрөнгө оруулалтын аж ахуй нэгжүүд: Нэгтгэлийн онцгой тохиолдлын үл хэрэгжүүлэлтийг ашиглах нь¹*
- СТОУС 10, НББОУС 28 нэмэлт өөрчлөлт *Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани эсвэл хамтарсан компанийн хооронд хөрөнгө борлуулах эсвэл оруулах¹*
- СТОУС 11 нэмэлт өөрчлөлт *Хамтарсан үйл ажиллагаан дах хувь оролцоо эзэмших үеийн бүртгэл¹*
- НББОУС 12 нэмэлт өөрчлөлт *Орлогын албан татвар: Ханишийн бодит бус алдагдалд хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөх нь²*
- СТОУС 14 *Зохицуулалтын хойшлогдсон дансууд⁵*
- СТОУС 15 *Харилцагчтай байгуулсан гэрээний орлого³*
- СТОУС 16 *Түрээс⁴*
- НББОУС 1, нэмэлт өөрчлөлт *Тодруулгын удиртгал¹*
- НББОУС 7, нэмэлт өөрчлөлт *Тодруулгын удиртгал²*
- НББОУС 16, НББОУС 38 нэмэлт өөрчлөлт *Элэгдэл ба хорогдуулгын хүлээн зөвшөөрөгдөх аргуудын тодруулга¹*
- НББОУС 16, НББОУС 41 нэмэлт өөрчлөлт *Хөдөө аж ахуй – Үрт ургамал²*
- НББОУС 27, нэмэлт өөрчлөлт *Тусдаа санхүүгийн тайлангууд–Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга¹*
- Жил тутмын сайжруулалтууд (2012-2014) *2014 оны 9 сард гарсан СТОУС-уудын нэмэлт өөрчлөлтүүд¹*

¹ 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

² 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

³ 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

⁴ 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

⁵ 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эсвэл түүнээс хойшхи санхүүгийн тайлангууддаа СТОУС-уудыг анхлан мөрдөх банкуудад хамааралтай тул энэ нь Банкинд хамаарахгүй болно.

Одоогоор Банк нь эдгээр стандартууд болон тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөх нь Банкны санхүүгийн байдалд нөлөө үзүүлэх эсэхийг үнэлж байна.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

Гадаадын валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр илэрхийлдэг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ.

Гадаад валютаар бүртгэсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээр хэмжигдэх, мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар бүртгэнэ.

Мөнгөөр илэрхийлэгдэх гадаад валютын тэнцлийн үлдэгдлийг төгрөгт хөрвүүлэхэд ашигласан албан ханшийг дор харуулав:

	2015.12.31-ний байдлаар	2014.12.31-ний байдлаар
	төгрөг	төгрөг
Ам. доллар	1,995.98	1,885.6
ЗТЭ	2,772.52	2,731.68
Евро	2,182.70	2,293.36
Юань	307.54	303.57
Иен	16.58	15.74

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь нэг байгууллагын санхүүгийн хөрөнгө мөн өөр нэг байгууллагын өр төлбөр эсвэл эздийн өмчийг өсгөдөг гэрээ хэлцлийг хэлдэг.

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Банк тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд “хэвийн нөхцөлтэй арилжаа” буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хэмжилт

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт нь тухайн хэрэглүүрийн зорилго, онцлог мөн удирдлагын уг хэрэглүүрийг олж авах болсон зорилгоос хамааран ангилагддаг. Бодит үнэ цэнэ нь орлого үр дүнгийн тайланд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүдийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна.

(iii) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэх санхүүгийн үүсмэл хэрэглүүрүүд

Зах зээлийн эрсдэлүүдийг удирдахын тулд Банк валютын форвард болон своп гэрээ хэлцлүүд гэсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашигладаг. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг “Санхүүгийн хэрэглүүрийн олз/(гарз)” дансанд бүртгэдэг. Санхүүгийн хэрэглүүрүүдэд агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг салгаж авч үзэх ёстой ба тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүд нь агуулагч гэрээний эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүдтэй нягт холбоогүй, мөн агуулагч гэрээг худалдах зорилгоор эзэмшээгүй ба анх хүлээн зөвшөөрөхдөө "Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх" гэж ангилаагүй тохиолдолд тэдгээрийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

(iv) Худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр

"Худалдах зорилгоор эзэмшиж буй" санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Хүүгийн болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцөлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь "Арилжааны цэвэр орлого" дансанд бүртгэнэ.

(v) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Энэ бүлгийн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь удирдлага анх хүлээн зөвшөөрөхдөө энэ бүлэгт оруулахаар шийдвэрлэсэн санхүүгийн хэрэглүүрүүд байна. Дараах нөхцөлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болох ба шийдвэрийг хэрэглүүр тус бүр дээр гаргана.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(v) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр (Үргэлжлэл)

Үүнд:

- ▶ Энэхүү шийдвэр нь хөрөнгө, өр төлбөрийг хэмжих эсвэл хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого, зардалд хүлээн зөвшөөрснөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвитойгоор бууруулахаар байвал;
- ▶ Эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл аль аль нь бөгөөд тэдгээрийг хүчин төгөлдөр эрсдэлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдаж, гүйцэтгэлийг нь бодит үнэ дээр нь суурилан хэмждэг байх;
- ▶ Санхүүгийн хэрэглүүр нь гэрээнд зааснаас бусад тохиолдолд мөнгөн урсгалыг ихээхэн хэмжээгээр өөрчлөх нэг эсвэл түүнээс олон тооны үүсмэл хэрэглүүрүүдийг агуулж байвал;

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ. Олсон хүүгийн орлогыг “Хүүгийн орлого” дансанд, гарсан хүүгийн зардлыг “Хүүгийн зардал” дансанд гэрээний нөхцөлийн дагуу хуримтлуулж бүртгэх ба ногдол ашгийн орлогыг төлбөрийн эрх үүссэн үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр санхүүгийн хэрэглүүрээс өөр байхгүй байна.

(vi) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтад өөрийн хөрөнгийн ба өрийн үнэт цааснууд багтана. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт ангилал дахь өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтууд нь “Худалдах зорилгоор эзэмшиж буй” ба “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” ангилалд ороогүй хөрөнгө оруулалтууд юм. Өрийн үнэт цаасууд нь тодорхойгүй хугацаагаар эзэмших хандлагатай, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах үүднээс эсвэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас борлуулах боломжтой хөрөнгө оруулалт юм.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(vi) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт (Үргэлжлэл)

Банк нь аливаа зээл, авлагуудыг “Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй. Анхны хэмжилтийн дараа борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Бодит бус ашиг ба алдагдлыг өөрийн хөрөнгө дэх (бусад дэлгэрэнгүй орлого) "Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц сан"-д бүртгэдэг. Уг хөрөнгө оруулалтыг борлуулах үед өөрийн хөрөнгөд өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг алдагдлыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг "эхэлж авснаа эхэлж зарлагадах" зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогоор бүртгэнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Энэхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрч, “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц сан”-гаас хасна.

(vii) Дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, тогтоосон хугацаатай, Банк дуусах хугацаа хүртэл нь эзэмших хандлага болоод чадвартай, үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг "Дуусах хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт" гэнэ.

Эхний хэмжилтийн дараа дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь орлогын тайлангийн "Хүүгийн орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв Банк бага биш дүнтэй “дуусах хугацаа хүртэл эзэмших” хөрөнгө оруулалтыг хугацаанаас нь өмнө худалдах эсвэл дахин ангилах бол (зарим нэг онцгой тохиолдлуудаас бусад) нийт бүлгээр нь “борлуулахад бэлэн” бүлэгт дахин ангилна. Үүнээс гадна Банк нь дараагийн хоёр жилд “дуусах хугацаа хүртэл эзэмших” бүлгээс аливаа нэг санхүүгийн хөрөнгийг дахин ангилахыг хориглодог.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(viii) Зээл болон урьдчилгаа

“Дотоодын банкуудад олгосон зээл”, “Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж”, “Урвуу буцаан худалдан авах хэлцэл” болон бусад хөрөнгө дэх “Бусад санхүүгийн хөрөнгө” дансад идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөртэй дараах үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад хөрөнгүүд багтана. Үүнд:

- ▶ Банк нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- ▶ Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн” гэж ангилсан санхүүгийн хөрөнгө оруулалтууд;
- ▶ Банк зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас анх оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэглүүрүүд.

Анхны хэмжилтийн дараа зээл болон урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлогын тайлангийн "Хүүгийн орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, зардлын дансанд “Үнэ цэнийн бууралтын алдагдал” –р хүлээн зөвшөөрнө.

(ix) Зээллэг

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэггүй, Банкны гаргасан санхүүгийн хэрэглүүрүүд зээллэг дотор өр төлбөр гэж ангилагддаг. Энэхүү дансанд 'Төв банкны үнэт цаас', 'Гадаад өр төлбөр', 'Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж', 'Дотоодын банкуудын харилцах, хадгаламж' болон бусад өр төлбөр дэх 'Бусад санхүүгийн өр төлбөр' багтана. Гэрээт зохицуулалтын агуулга нь бэлэн мөнгө эсвэл өөр бусад санхүүгийн хөрөнгийг эзэмшигчид шилжүүлэх үүргийг Банкинд үүсгэх эсвэл тогтсон дүнтэй бэлэн мөнгө эсвэл өөр бусад санхүүгийн хөрөнгөөр тогтсон тооны өөрийн хөрөнгийн хувьцааг солихоос өөр аргаар өр төлбөрийг барагдуулахад хүргэдэг. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг зэрэг агуулж байгаа нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг анх гаргасан өдөр нь салгаж бүртгэнэ.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(ix) Зээллэг (Үргэлжлэл)

Энэ хэрэглүүрээс орох цэвэр орлогын нэг хэсгийг түүний бодит үнэ цэнэд (төсөөтэй өөр бусад хэрэглүүрүүдийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үнэ дээр үндэслэн голдуу тодорхойлдог) нь үндэслэн гаргасан өдөр өрийн бүрэлдэхүүн хэсэгт хуваарилна. Тухайн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн нийт дүнгээс өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт тусад нь тодорхойлсон дүнг хасч, үлдсэн дүнг өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт оногдуулна. Өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгээс өөр, нийлмэл санхүүгийн хэрэглүүрт агуулагдаж буй үүсмэл шинж чанартай (худалдан авах опцион гэх мэт) аливаа нэг бүрэлдэхүүнийг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт оруулна.

Анхны хэмжилтийн дараа зээллэгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Зээллэгийн хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох тухайн гүйлгээтэй холбогдон гарсан аливаа зардлуудыг авч үзнэ.

(x) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

“Борлуулахад бэлэн” ангиллаас дахин ангилсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрсөн өмнөх олз гарзыг хөрөнгө оруулалтын үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, орлого, зардлын дансанд бүртгэнэ. Хорогдуулсан шинэ үнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хоорондох аливаа нэг зөрүүг мөн хөрөнгийн үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж тодорхойлбол өмнөх хугацаанд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн дүнг орлого, зардлын дансруу шилжүүлэн бүртгэнэ.

Хэрэв хөрөнгө нь зээл, авлагын тодорхойлолтод нийцэж байгаа бөгөөд Банк хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусах хугацаа хүртэл нь эзэмших хандлага болоод чадвартай бол Банк үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг “Худалдах зорилгоор эзэмшиж буй” гэсэн ангиллаас “Зээл ба авлага” гэсэн ангилалд дахин ангилж болно. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан, мөн орж ирэх мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолон тооцсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүгийн түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Дахин ангилал нь удирдлагын шийдвэрээс хамаарах ба хэрэглүүр тус бүр дээр тодорхойлно. Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа аливаа нэг санхүүгийн хэрэглүүрийг “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” бүлэгт дахин ангилаагүй.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(xi) “Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал

Ажил гүйлгээний үнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн ажил гүйлгээний бодит үнэ цэнээс ялгаатай эсвэл нээлттэй зах зээлийн мэдээллийн үнэлгээний аргад суурилсан байвал Банк бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг (Эхний өдрийн ашиг ба алдагдал) нэн даруй орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц ажиглагддаггүй мэдээлэлд суурилсан бол ажил гүйлгээний үнэ болон үнэлгээний загварын зөрүүг өгөгдөл ажиглагдахуйц болсон эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх үед орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн нэг хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ▶ Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- ▶ Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
 - ▶ Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
 - ▶ Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (Үргэлжлэл)

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('репо')-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгө болон хуримтлагдсан хүүг Буцаан худалдан авах гэрээгээр тусгах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж үзэн үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Харилцагч талд зээлдүүлсэн үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох ангилалд үлдээнэ.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл ('урвуу репо')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд “Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа” гэж тусгана. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг “Хүүгийн орлого” гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх бодит үнэ цэнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон дилерийн үнэ (урт позицийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицийн хувьд эрэлтийн үнэ) дээр үндэслэнэ.

Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнийн тодорхойлолт (Үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд хийсэн дэс дараалалтай гүйлгээний үр дүнд хөрөнгө борлуулснаас орж ирэх мөнгөн дүн болон өр төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн юм. Бодит үнэ цэнийн хэмжилт нь хөрөнгийг борлуулсан эсвэл өр төлбөрийг шилжүүлсэн гүйлгээ нь дараах зах зээлийн аль нэгэнд хийгдсэн гэсэн таамаглалд үндэслэнэ. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд,
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн болон хамгийн ашигтай зах зээл нь Банкны хувьд оролцож болохуйц зах зээлүүд байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөлд үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэх эсвэл уг хөрөнгийг ашигласнаар эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэх зах зээлийн бусад оролцогч талд худалдах нөхцөлд тооцно.

Банк нь бодит үнэ цэнэ тооцохдоо шаардлагатай мэдээллүүд нь хангалттай үед үнэлгээний аргачлалуудыг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах бодит үнэ цэнийн түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн биржид бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ,

Түвшин 2 - бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх, хамгийн доод түвшний өгөгдөл нь шууд болон шууд бусаар ажиглагдах боломжтой үнэлгээний аргачлалууд

Түвшин 3 - бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх, хамгийн доод түвшний өгөгдөл нь ажиглагдах боломжгүй үнэлгээний аргачлалууд

Тайлант хугацааны эцэст Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрүүдийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг (бодит үнэ цэнийн хэмжилтэнд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн) дахин нягталж үздэг.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнийн тодорхойлолт (Үргэлжлэл)

Хөрөнгийг үнэлэхэд гадны үнэлгээчдийг оролцуулж болно. Гадны үнэлгээчдийг сонгохдоо зах зээлийн мэдлэг, нэр хүнд, хараат бус байдал болон мэргэжлийн стандарт хангасан зэрэг шалгууруудад үндэслэдэг.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон хэрхэн хэмжигдсэн талаарх бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 35-т толилуулсан болно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоогоор тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад буюу бүтцийн өөрчлөлтөд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө

Банк харьцангуй цөөн зээлдэгчидтэй (харилцагч болон бусад зээлдэгчид)-тэй учир санхүүгийн хөрөнгүүдийг нэг бүрчлэн үнэлдэг. Жишээ нь: Банк бүх хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгүүдийн хувьд үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг тус бүр үнэлдэг.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын орлого, зардлын дансанд 'Үнэ цэнийн бууралтын алдагдал'-аар хүлээн зөвшөөрнө.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүгийн орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг “Хүүгийн орлого”-н нэг хэсэг болгон орлого, зардлын дансанд бүртгэнэ.

Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл банкинд шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсч эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл тухайн үед нь ‘Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт’ дансанд бүртгэнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүгийн хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүгийн хувь нь хувьсах нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

(ii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үздэг.

Өрийн хэрэглүүрүүдийг борлуулахад бэлэн гэж ангилсан тохиолдолд Банк хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуураар тэдгээрт үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн үнэлдэг. Гэсэн хэдий ч үнэ цэнийн бууралтыг бүртгэх дүн нь хорогдуулсан өртөг болон өнөөгийн бодит үнэ цэнийн зөрүүнээс тухайн хөрөнгө оруулалттай холбоотойгоор орлого, зардлын дансанд өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх хуримтлагдсан алдагдалтай тэнцүү байна.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)

(ii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт (Үргэлжлэл)

Ирээдүйн хүүгийн орлого нь бууруулсан бүртгэлийн үнэ дээр суурилах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд “Хүүгийн орлого”-ын хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант хугацаанд орлого, зардлын дансанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах зээлийн үйл явдлын улмаас өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ өсвөл үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн жилийн орлого, зардлын дансаар дамжуулан буцаана.

“Борлуулахад бэлэн” ангиллын өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурах нь бодит нотолгоонд багтана. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлого зардлаар өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлого, зардлын дансаар дамжуулан буцаахгүй, харин үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Үндсэн цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулдаг.

Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Банкинд орж ирэх нь тодорхой болсон бөгөөд түүнийг найдвартай хэмжиж болохуйц үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх (Үргэлжлэл)

Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

(i) Хүүгийн орлого ба зардал

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэглүүрүүд, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан хүүтэй санхүүгийн хөрөнгө, “Бодит үнэ цэнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувь (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) хэрэглэн бүртгэнэ. Тооцоололд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцөлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэглүүрт шууд хамааралтай, зээлийн ирээдүйн алдагдал биш харин үр ашигт хүүгийн салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаадаг.

Хэрэв Банк төлөх төлбөр болон хүлээн авах орлогын талаар хийсэн өөрийн тооцооллоо өөрчилвөл санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг тохируулна. Залруулсан бүртгэлийн дүнг анхны үр ашигт хүүгийн түвшин дээр үндэслэн тооцоолох ба бүртгэлийн дүнд орсон өөрчлөлтийг санхүүгийн хөрөнгийн хувьд ‘Хүүгийн орлого’, санхүүгийн өр төлбөрийн хувьд ‘Хүүгийн зардал’-аар бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн эсвэл ижил төстэй бүлэг санхүүгийн хөрөнгийн бүртгэлийн дүнг үнэ цэнийн бууралтын алдагдлын улмаас бууруулсан бол үнэ цэнийн бууралтыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахдаа хэрэглэсэн хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө.

(ii) Шимтгэлийн орлого

Банкны шимтгэлийн орлого нь ихэвчлэн банк хоорондын төлбөр тооцоо болон гадаад банкуудын төлбөр тооцооны шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг ихэвчлэн үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь аккрузал сууриар хүлээн зөвшөөрдөг.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлийг багтаадаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд богино хугацааны мэдэгдлээр зарцуулж болох хугацаагүй болон гурван сараас бага хугацаатай санхүүгийн хөрөнгө орно. Зарцуулалтад хязгаарлалт хийснээс эсвэл хөрвөх чадвар муугаас шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулаагүй болно.

Алт ба үнэт метал

Олон улсын стандартын дагуу алт болон үнэт металыг гадаадын банкинд алтан болон мөнгөн гулдмай хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь гадаад нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металлууд нь трой унцаар хэмжигдэн бүртгэгдэх ба Банкны албан ханшаар үнэлэгдэн төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Алтны арилжааны албан ханшийг Лондонгийн Алтны захын холбооноос зарласан үнэт металын ам, долларын ханшид тулгуурлан, Банкны зарласан төгрөг-ам, долларын харьцах ханшаар хөрвүүлж төгрөгөөр илэрхийлдэг. Банк нь алтыг ийм байдлаар эзэмшихээс гадна Монгол дахь үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээс цэвэршүүлээгүй алтыг худалдан авч, цэвэршүүлсний дараа гадаад зах зээлд худалддаг.

Алт ба мөнгийг бодит үнэ цэнээр нь санхүүгийн байдлын тайланд тусгах бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алтны зах зээлийн үнийг харгалзан үздэг. Дахин үнэлгээний олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит бус ашиг алдагдлыг жилийн эцэст хуримтлагдсан ашгаас өөрийн хөрөнгө дэх “Бусад нөөц”-ийн “Үнэт металын үнэлгээний нөөц” -рүү хаана.

Бусад үнэт металыг (мөнгөжөөгүй алт ба мөнгө, зоос, соёлын үнэт зүйлс гэх мэт) бараа материалаар хүлээн зөвшөөрч, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

Хураан авсан хөрөнгө

Банкны бодлого нь хураан авсан хөрөнгийг дотоод үйл ажиллагаандаа ашиглах эсвэл худалдан борлуулахыг тодорхойлдог. Дотоод үйл ажиллагаанд ашиглах хөрөнгүүдийг холбогдох хөрөнгийн ангилалд шилжүүлнэ. Худалдан борлуулахаар тодорхойлогдсон бол уг хөрөнгүүдийг “Худалдах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө” данс руу ангилдаг. Банк ашиглалтыг нь тодорхойлоогүй байгаа хураан авсан хөрөнгийг энэ дансанд бүртгэсэн болно.

Хураан авсан хөрөнгийг эхлээд тэдгээрийн бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой гарсан зардлыг хассан дүн болон хөрөнгийг хураан авсан өдрөөр төлөгдөөгүй байгаа харгалзах зээлүүдийн хорогдуулсан дүнгийн аль багаар хүлээн зөвшөөрөх ба зээл, урьдчилгааг холбогдох үнэ цэнийн бууралтын сангийнх нь хамт санхүүгийн байдлын тайланд үл хүлээн зөвшөөрнө.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хураан авсан хөрөнгө (Үргэлжлэл)

Дараагийн тайлант хугацаанд хураан авсан хөрөнгийг өртөг ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь “Бусад хөрөнгө”-д бүртгэнэ.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

Худалдах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой гарсан зардлыг хассан дүнгийн аль багаар хэмждэг. Хэрэв хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглахаас илүүтэйгээр борлуулснаар үлдэгдэл өртгийг бүрэн нөхөх боломжтой бол борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө гэж ангилна. Энэ нөхцөлийг хангахын тулд хөрөнгө нь зах зээл дээр тохиромжтой үнээр идэвхтэй арилжаалагдах, хөрөнгө болон худалдах багц нь өөрийн одоо байгаа нөхцөл байдлаараа түргэн борлогдох боломжтой, удирдлага худалдан борлуулахаар шийдсэн, нэг жилийн дотор зарагдах магадлал өндөртэй байх ёстой.

Үндсэн хөрөнгө

Барилгыг анхлан бүртгэхдээ өртгөөр нь дараа нь бодит үнэ цэнээс нь хуримтлагдсан элэгдэл болон дахин үнэлгээний өдрөөр хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ нь бүртгэлийн дүнгээсээ материаллаг бус дүнгээр зөрүүтэй эсэхийг шалгахын тулд үнэлгээг давтамжтай гүйцэтгэдэг.

Барилгыг дахин үнэлэх давтамж нь үнэлж буй хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарна. Үнэлж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнгээсээ материаллаг хэмжээгээр зөрүүтэй байвал цаашид дахин үнэлэх шаардлагатай. Зарим барилгын бодит үнэ цэнэ нь их хэмжээгээр хувьсан өөрчлөгддөг тул тэдгээрийг жил бүр үнэлэх шаардлагатай байдаг. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь материаллаг бус барилгын хувьд дахин үнэлгээг тогтмол хийх шаардлагагүй харин таван жил тутам тухайн хөрөнгийг дахин үнэлэх шаардлагатай байж болно.

Дахин үнэлгээнээс үүссэн илүүдлийг эздийн өмч дэх үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц санд тайлагнана. Өмнө нь дахин үнэлэгдэж, үнэлгээний бууралтыг орлого, зардлын дансанд тусгасан хөрөнгийн хувьд тайлант хугацааны дахин үнэлгээний илүүдлийг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө. Харин өмнө нь дахин үнэлэгдэж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц санд дахин үнэлгээний илүүдэл тусгасан хөрөнгийг хувьд тайлант хугацааны дахин үнэлгээний бууралтыг уг нөөц сангийн холбогдох илүүдлийн хэсэгтэй цэвэршүүлэх ба бусад тохиолдолд орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Бусад үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль тохиромжтой гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үндсэн хөрөнгө (Үргэлжлэл)

Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварын зардлыг гарсан тайлант хугацаанд ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоогоор тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохирохыг өөрчилснөөр хүлээгдэж буй ашиглалтын хугацаа өөрчлөгдөх ба үүнийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Үндсэн хөрөнгийн ойролцоогоор тооцсон ашиглалтын хугацааг доор үзүүлэв.

Барилга	40-60 жил
Тавилга, тоног төхөөрөмж	8-10 жил
Компьютер, техник хэрэгсэл	5-10 жил
Тээврийн хэрэгсэл	6-8 жил

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа болон элэгдлийн аргыг санхүүгийн тайлант жил бүрийн эцэст хянаж, шаардлагатай бол тохируулдаг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт болон борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн аливаа олз, гарзыг (борлуулснаас орж ирэх орлого ба дансны үнийн зөрүү) ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх. бөгөөд тухайн хөрөнгийн дахин үнэлгээний ашиглагдаагүй хэсгээр өөрийн хөрөнгө дэх хуримтлагдсан алдагдлыг шууд бууруулна.

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж, лиценз орно. Биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэнэ. Дараагийн удаад биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгана.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг орлого, зардлын дансанд ‘Захиргааны зардал’-ын нэг хэсэг болгон толилуулна.

Биет бус хөрөнгийн өртгийг шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь ойролцоолон тооцсон ашиглалтын хугацаа болох 4 жилээр хорогдуулна.

Орлогын албан татвар

Монгол улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг байна. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүн болон ашиглалтын өртгийн аль өндрөөр тодорхойлогдоно. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ.

Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Өмнө нь дахин үнэлэгдэж байсан ба дахин үнэлгээний зөрүүг нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч байсан хөрөнгүүд (энэ тохиолдолд өмнөх аливаа нэг үнэлгээний дүн хүртэлх хэмжээгээр бусад дэлгэрэнгүй орлогод мөн хүлээн зөвшөөрнө)- ээс бусад хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдалгүй болсон эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн эргэн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан ойролцоо тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Энэ тохиолдолд хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл өсгөдөг. Өмнөх жилүүдэд тухайн хөрөнгө дээр үнэ цэнэ бууралтын алдагдал хүлээн зөвшөөрөөгүй байсан бол энэхүү өсөлтийн дүн тодорхойлж болох байсан бүртгэлийн дүнгээс (элэгдлийг хассан) илүү гарч болохгүй. Ийм буцаалтыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрөх ба тухайн хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр бүртгэх тохиолдолд буцаалтыг дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэнэ.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилтнуудаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилийн зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг тухай бүрт нь олгодог.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө гэдэг нь Монгол улсын Засгийн газраар бүрэн баталгаажсан, эзэмшигчигчийн зөвшөөрлөөр гүйлгээнд зориулан гаргасан мөнгөн тэмдэгт юм. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг нэрлэсэн үнээр нь санхүүгийн байдлын тайлангийн өр төлбөр хэсэгт бүртгэдэг.

Сангууд

Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа, энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Дүрмийн сан

Дүрмийн сан нь эзэмшигчдийн хөрөнгө гэж ангилагддаг.

Ерөнхий нөөцийн сан

Монгол улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу тухайн жилийн цэвэр ашгийн 40 хувиас доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг (хамгийн ихдээ 60%) Улсын төсөвт шилжүүлдэг. Ерөнхий нөөцийн сан нь хуримтлуулсан цэвэр ашгийн тухайн хэсгээс бүрддэг ба Банк түүнийгээ бүрэн захиран зарцуулах эрхтэй. 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ерөнхий нөөцийн сан үлдэгдэлгүй байсан.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад сангууд

Бусад санд валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус олз, гарз, мөнгөжсөн алт болон үнэт металын (мөнгө) дахин үнэлгээний олз, гарз, дахин үнэлгээний нөөц сан (барилга байгууламжтай холбоотой) болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын санг оруулдаг. Банк өөрсдийн бодлогынхоо дагуу орлого, зардлаар өмнө нь хүлээн зөвшөөрсөн ханшийн тэгшитгэлийн бодит бус олз, гарз болон мөнгөжсөн алт, үнэт металын (мөнгө) дахин үнэлгээний олз, гарзыг бусад сангуудад жил бүрийн эцэст шилжүүлдэг байна.

Холбоотой талын гүйлгээ

Энд дурьдагдсан талыг Банкны холбоотой тал гэж энэхүү санхүүгийн тайлагналд дараах нөхцөлүүдийг үзсэн болно. Үүнд:

- ▶ Холбоотой тал нь шууд эсвэл шууд бусаар нэг болон түүнээс дээш зуучаар дамжуулан Банкныг хянах чадвартай эсвэл Банкны санхүү ба үйл ажиллагааны шийдвэрт томоохон нөлөө үзүүлэх чадвартай, эсвэл хамтын хяналт дор байдаг бол;
- ▶ Холбоотой тал болон Банк нь нэг хяналтын дор байдаг бол;
- ▶ Тал нь Банкны гол удирдах ажилтан эсвэл гол удирдах ажилтны гэр бүлийн гишүүд бол, эсвэл эдгээр хүмүүсийн хяналт, хамтын хяналт эсвэл томоохон нөлөөлөл дор байдаг байгууллага бол;
- ▶ Тал нь (1)-д дурдсан талын гэр бүлийн гишүүд эсвэл эдгээр хүмүүсийн хяналт, хамтын хяналт эсвэл томоохон нөлөөлөл дор байдаг байгууллага бол эсвэл,
- ▶ Холбоотой тал нь Банкны болон Банкны холбоотой талын ажилчдын эрх ашгийн төлөө ажилладаг ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө юм.

Хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд гэдэг нь тухайн хувь хүнийг Банктай ямар нэг харилцаа хийхэд тэдний зүгээс болон тэдэнд нөлөө үзүүлж болох гэр бүлийн гишүүд юм.

Холбоотой талуудтай хийсэн бүх гүйлгээ болон дансдын үлдэгдлийн мэдээллүүдийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тусгасан бөгөөд Тодруулга 37-д задаргааг толилуулсан.

Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Банкны тайлант хугацааны эцсийн санхүүгийн байдлын тайланд нэмэлт мэдээлэл өгөх тайлант хугацааны дараах үйл явдлуудыг (залруулах үйл явдлууд) санхүүгийн тайланд тусгасан болно. Банкны санхүүгийн тайланг залруулахгүй, материаллаг үйл явдлуудыг Тодруулга 39-д тусгасан болно.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг. Хамгийн том үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг дор үзүүлэв. Үүнд:

Сангийн яамнаас авсан зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлт болон дотоодын банкинд олгосон зээлийн анхны бүртгэл

Банк Сангийн яамнаас зээл авсан ба үүнээс 22,205 сая төгрөг (2014: 23,772 сая төгрөг)-ийн эх үүсвэр нь Германы Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт буюу Сангийн яаманд олгосон бүс нутгийн хөгжлийг дэмжих Азийн хөгжлийн банк болон Германы Засгийн газрын санхүүжилт юм. Энэхүү зээл нь жилийн 0.75 хувиас 1 хувь хүртэл маш бага хүүтэй, эдийн засгийн зорилтот салбар эсвэл бусад тодорхой зорилгоор бага хүүтэйгээр олгогдох нөхцөлтэй болно. Удирдлага ийм төрлийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрхөд олз үүсэх эсэх талаар нягталж үзсэн. Энэхүү санхүүжилт нь бүс нутаг болоод нийгмийн хөгжилд зориулагдсан учир ямар нэгэн ашиг олох зорилгоор нийтэд олгогдох ёсгүй хэмээн дүгнэжээ. Түүнчлэн, эдгээр байгууллагуудаас Монголын банкуудад харьцангуй бага хүүтэй санхүүжилт олгосон. Тиймээс анхлан хүлээн зөвшөөрөлтийн олз бүртгээгүй болно.

Ийм төрлийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр Банк нь бусад шаардлага хангасан банкуудад харьцангуй бага хүүтэй зээлийг олгох боломжтой болсон. Удирдлага ийм төрлийн хэрэглүүрүүдээс анхлан хүлээн зөвшөөрөлтийн гарз бүртгэх эсэхийг нягталж үзсэн бөгөөд ажил гүйлгээг холбоотой бус талуудтай боломжит зах зээлийн хүүгээр хийж байгаа тул гарз бүртгэхгүй байх нь зөв гэж үзсэн. Дээрх дүгнэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэглүүрүүдийг салангид зах зээлийн хэсэг гэж тооцсон.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлт

НББОУС 39-ийн дагуу борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнэд нь суурилан анхлан хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Хэрэв тухайн гүйлгээний хувьд идэвхтэй зах зээл байхгүй бол уг гүйлгээнүүдийг зах зээлийн эсвэл зах зээлийн бус үнээр хийгдсэн эсэхийг тодорхойлохын тулд үнэлэлт хийдэг. Үнэлэлтийн суурь нь холбоогүй талуудтай хийсэн ижил төрлийн гүйлгээнүүдийн үнэ болон үр ашигт хүүний шинжилгээ байдаг.

Тодруулга 15-д толилуулснаар, Банк 133,749 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, зах зээлийн хүүгээс доогуур хүү болох жилийн 4%-ийн нэрлэсэн хүүтэй Хөгжлийн банкны үнэт цаасуудыг эзэмшиж байна. Эдгээр үнэт цаасуудыг анхлан хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ нь 105,146 сая төгрөг байсан ба тэдгээрийн нэрлэсэн болон бодит үнэ цэнийн зөрүү 28,603 сая төгрөгийг тайлант жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байна.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Банк Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар, мөн эрсдэлийн удирдлагын зорилгоор банкуудтай үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн гэрээг байгуулдаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрээс олж авах боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг ажиглагдахуйц зах зээлийн өгөгдлүүдээс гарган авах ба ажиглагдахуйц боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй байгаа тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Уг үнэлэмжид урт хугацаат үүсмэл хэрэглүүрүүдийн хувирамтгай байдал, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хямдруулалтын хувь, урьдчилан төлөх хувь, эргэн төлөгдөхгүй байх төсөөлөл гэх мэт загварын өгөгдлүүд болон хөрвөх чадварын төсөөллүүд багтана. Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэлгээний талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 35-д толилуулсан болно.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Банк нь бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байгаа, борлуулахад бэлэн өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтууд дээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүртгэдэг. “Их хэмжээ”, “Урт хугацаа” гэдгийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Энэ үнэлэмжийг хийхдээ Банк нь хувьцааны үнийн өөрчлөлтийн түүх, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө ямар хугацаанд, ямар хэмжээгээр доогуур байсан зэрэг олон хүчин зүйлийг үнэлж үзнэ.

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэгийн үнэ цэнийн бууралт

Төрийн банкны хувьцааг худалдан авах Засгийн газрын шийдвэрийн хүрээнд Банк 2014 онд ХДК-д богино хугацаат санхүүгийн дэмжлэг олгосон. ХДК нь Төрийн банк ХХК-ийн 75%-г эзэмшдэг. Гэрээнд зааснаар, Төрийн банк ХХК-ийн хувьчлалын орлогоос уг санхүүгийн дэмжлэгийг төлүүлнэ гэж заасан байдаг. Эдгээр санхүүгийн тайлангуудын өдрөөр, Төрийн банк ХХК хувьчлагдаагүй байсан бөгөөд энэ нь удирдлагуудад тодорхойгүй байдал үүсгэсний улмаас 2014 онд ХДК-д олгосон санхүүгийн дэмжлэгт 100 хувийн үнэ цэнэ бууралтын сан байгуулсан ба 2015 онд уг санд хөдөлгөөн гараагүй.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт

Банк Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн. Үүнд:

- ▶ Банк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;
- ▶ Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкны татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй; Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Банкны үр өгөөжид нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- ▶ Хэдийгээр Банк Эрх хүлээн авагчийн хүрээнд банкуудад зээл олгож болох боловч энэхүү зээлийг хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эргүүлэн төлөх баталгааны хуулийн дагуу Засгийн газрын үүргийг биелүүлэхийн тулд Засгийн газрын нэрийн өмнөөс олгох болно. Ийм учраас эдгээр зээлийн авлагын үр өгөөж нь Засгийн газрын бонд хэлбэртэй байна гэж удирдлага үзэж байна.
- ▶ Үүнээс гадна Эрх хүлээн авагчаас хүлээн авсан үр өгөөж нь өөрчлөлт багатай байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн, Банк нь хэдийгээр эрх хүлээн авсан банкнуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлагагүй гэж үзэж байна.

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт

Банк Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон ХДК-ийн хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн. Үүнд:

- ХДК дахь эрх мэдэл,
- ХДК-ийн үйл ажиллагаан дахь оролцооноос өгөөж хүртэх нөхцөл байдал болон эрх,
- ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Банкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар.

Банк ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож чаддаг бол Банк ХДК-д эрх мэдэлтэй гэж үзнэ. ХДК-ийн дүрмийн дагуу, Үндэсний хороо нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга нь байна.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт (Үргэлжлэл)

Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь:

- Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
- Корпорацийн гүйцэтгэх захирал;
- Гурван гишүүн нь Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар томилогддог.

Корпоратитай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны долоон гишүүний саналаар батлагдах ба аль нэг гишүүн нь ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давамгайлсан эрхгүй байна. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч нь Үндэсний хороог даргалах боловч ХДК-ийн үйл ажиллагааг удирдах явцуу эрхгүй бөгөөд Банк нь бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д хяналт болон нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд Удирдлага ХДК-ийг санхүүгийн тайландаа нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Тасралтгүй байх зарчим

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2014, 2015 онуудын 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны өөрийн хөрөнгө сөрөг, цэвэр өр төлбөртэй гарсан ба Банк нь үндэсний мөнгөн тэмдэгт гаргагч тул төгрөгийн хөрвөх чадварын эрсдэлд орохгүй гэж үзээд ирээдүйд (урьдчилан харж болох) тасралтгүй байх зарчмаас шалтгаалан Банк үйл ажиллагаа үргэжлүүлэхгүй байх эрсдэл гарахгүй гэдэгт Удирдлага итгэлтэй байна.

Барилгын дахин үнэлгээ

Банк нь барилга байгууламжаа бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдөх дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг. Банк 2013 онд барилгын бодит үнэ цэнээ үнэлүүлэхээр хараат бус үнэлгээний мэргэжилтэнтэй гэрээ байгуулсан.

Барилгуудыг тухайн хөрөнгийн шинж чанар, байршил, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн нарийн хүчин зүйлүүдэд тохируулан үнийг харьцуулах замаар зах зээлийн үнэлгээний сууриар үнэлсэн. Удирдлага 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх барилгын бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ их дүнгээр өөрчлөгдөөгүй гэж үнэлсэн ба энэхүү үнэлгээ нь удирдлагаас барилгуудтай холбоотой өөрсдийн туршлага болон Тодруулга 35-д үзүүлсэн бусад таамаглалуудын талаарх үнэлэмж шаарддаг байна.

3. ХҮҮГИЙН ОРЛОГО

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Дотоодын банкуудад олгосон зээл	78,491	126,153
Засгийн газрын үнэт цаас - хямдруулсан өртгөөр	26,420	373
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	2,289	2,080
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	60,015	19,510
Дотоодын үнэт цаас	25,709	16,578
Бусад хүүгийн орлого	658	164
	<u>193,582</u>	<u>164,858</u>

4. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	74,197	89,440
Гадаад өр төлбөр	207,042	139,997
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	–	5,072
Дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон урамшуулал	44,912	–
Дотоодын банкуудын хадгаламж	4,210	954
Бусад хүүгийн зардал	17,652	4,643
	<u>348,013</u>	<u>240,106</u>

5. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖААНЫ ЦЭВЭР АШИГ/(АЛДАГДАЛ)

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Алтны арилжааны ашиг	4,315	23,240
Алтны дахин үнэлгээний бодит бус алдагдал	(4,242)	(6,873)
Бусад үнэт металын арилжааны ашиг/(алдагдал)	(1,214)	9,195
	<u>(1,141)</u>	<u>25,562</u>

6. ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ЦЭВЭР АШИГ/(АЛДАГДАЛ)

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Валютын ханшийн хөрвүүлгийн бодит бус ашиг/(алдагдал)	(58,703)	(370,027)
Валютын ханшийн зөрүүний бодит ашиг	91,093	289,928
Валют арилжааны ашиг/(алдагдал)	5,386	6,938
	<u>37,776</u>	<u>(73,161)</u>

7. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН ЦЭВЭР АЛДАГДАЛ

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн алдагдал-бодит	(8,434)	(281,145)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн алдагдал-бодит бус	(329,575)	(19,232)
	<u>(338,009)</u>	<u>(300,377)</u>

8. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ АШИГ, ЦЭВЭР

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаарх үнэт цаасны арилжааны ашиг	65	103
	<u>65</u>	<u>103</u>

9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Хураамж ба шимтгэлийн орлого	3,677	3,210
Үндсэн хөрөнгийн түрээсийн орлого	548	559
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	37	–
Хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын орлого	875	2,536
Бусад үйл ажиллагааны орлого	2,355	331
	<u>7,492</u>	<u>6,636</u>

10. ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН БУЦААЛТ/(АЛДАГДАЛ)

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Бусад хөрөнгө (Тодруулга 21)	6,246	(85,044)
Дотоодын банкуудад олгосон зээл (Тодруулга 20)	150	3,818
	<u>6,396</u>	<u>(81,226)</u>

11. ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Цалин, урамшуулал	9,489	8,255
Нийгмийн хөгжлийн сангийн зардал	2,000	3,000
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл ба хорогдол (Тодруулга 23)	2,397	2,476
Холбооны болон ашиглалтын зардал	1,526	1,485
Хуулийн болон мэргэжлийн үйлчилгээний зардал	1,133	1,626
Харуул хамгаалалтын зардал	1,177	996
Зар мэдээлэл, судалгааны ажлын зардал	843	933
Тээвэр болон томилолтын зардал	588	708
Бусад	2,519	2,327
	<u>21,672</u>	<u>21,806</u>

12. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БУСАД ЗАРДАЛ

Үйл ажиллагааны зардал		
Мөнгөн дэвсгэрт хэвлүүлэх, тээвэрлэх зардал	811	11,737
Алтны тээвэрлэлтийн зардал	1,054	1,263
Токио Мицүбиши Юү Эф Жи, Сингапур банкнаас авсан алтны урьдчилгаа санхүүжилтийн шимтгэл, Сүмитомо Мицью Банкинг Корпараци Сөүлтэй холбоотой гэрээний хураамж болон алт цэвэршүүлэлтийн зардлууд	6,891	2,031
	<u>8,756</u>	<u>15,031</u>
Бусад зардал		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны болон борлуулсны гарз	12	36
Бусад зардал	916	891
	<u>928</u>	<u>927</u>
Нийт	<u>9,684</u>	<u>15,958</u>

13. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Бэлэн мөнгө	53,793	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж (Тодруулга 14)		
- Богино хугацаат гадаад валютын хадгаламж	183,361	207,777
- Хугацаагүй хадгаламж	781,784	1,083,418
- Зээлжих тусгай эрхийн хадгаламж	118,988	117,275
	<u>1,137,926</u>	<u>1,466,460</u>

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор дээрх дүнгүүдийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэж тайлагнасан болно.

14. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Богино хугацаат гадаад валютын хадгаламж	183,361	207,777
Хугацаагүй хадгаламж	781,784	1,083,418
Зээлжих тусгай эрхийн хадгаламж	118,988	117,275
Хязгаарласан бэлэн мөнгө	801	758
Дэлхийн банкинд оруулсан хувь, хөрөнгө	125	118
Бусад хувь хөрөнгө	4	4
	<u>1,085,063</u>	<u>1,409,350</u>

Богино хугацаат гадаад валютын хадгаламж

Үүнд гадаадын Төв банкуудад ам.доллар болон английн фунтээр илэрхийлэгдсэн 29 хүртэлх хоногийн хугацаатай (2014 онд 51 хоног) богино хугацаат хадгаламжууд багтана.

Хугацаагүй хадгаламж

Үүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансууд багтана.

Зээлжих тусгай эрхийн хадгаламж

Энэ үлдэгдэл нь Банкнаас ОУВС-д оруулсан хувь хөрөнгөтэй холбоотой зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 42.9 сая зээлжих тусгай эрхтэй тэнцүү (2014 онд 42.9 сая зээлжих тусгай эрх) илэрхийлэгдсэн ба энэхүү үлдэгдэлд хүү тооцдог.

Хязгаарлагдсан бэлэн мөнгө

Үүнд гуравдагч талын хүсэлтээр Цюрихийн харьяа Шүүхээс хязгаарлалт тогтоосон 397,703 швейцар франк буюу 801 сая төгрөг (2014 онд 758 сая төгрөг) орно. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 29-өөс харна уу.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө

Энэ нь Дэлхийн банкны группийн гишүүн болох шаардлагын дагуу Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа (Тодруулга 28-с харна уу) ба хүү тооцдоггүй.

Бүх үлдэгдэл дүнгүүд хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй бөгөөд Удирдлагын зүгээс энэхүү хөрөнгө нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна.

14. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө (Үргэлжлэл)

Эдгээрийн аль нь ч барьцаа хөрөнгөөр бүртгэгдээгүй. Удирдлага эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо гэж итгэж байгаа. Газар зүйн байршлын шинжилгээ, валютын ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 33-аас үзнэ үү.

15. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-БОРЛУУЛАХАД БЭЛЭН

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Борлуулахад бэлэн өрийн үнэт цаас		
Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	119,726	113,133
АНУ-ын Засгийн газрын үнэт цаас	197,687	185,990
Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны (ОУСБХБ) үнэт цаас	3,988	3,773
РАМП хөрөнгө оруулалтын данс	201,187	189,681
Монголын ипотекийн корпорациас гаргасан ИЗББ	1,819,314	748,742
Хөгжлийн банкны үнэт цаас	105,945	–
Борлуулахад бэлэн өмчийн үнэт цаас		
МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт, бодит үнэ цэнээр	5,055	428
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр	6,142	5,192
	<u>2,459,044</u>	<u>1,246,939</u>

“РАМП” хөрөнгө оруулалтын данс

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл нь 0.31 сая ам.доллар (615 сая төгрөг)-ийн мөнгөн хөрөнгө, 100.49 сая ам.доллар (200,572 сая төгрөг)-ийн үнэт цааснаас бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансыг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан.

Хөрөнгө оруулалтын данс дахь үнэт цаасны дийлэнх хэсгийг АНУ-ын Засгийн газрын бонд болон бусад орны Засгийн газрын байгууллагаас гаргасан үнэт цаас бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн рейтинг эсвэл Мүүдийс болон Фичийн рейтингийн аль багаар үнэлэхэд АА-ААА зэрэглэлтэй байна.

15. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-БОРЛУУЛАХАД БЭЛЭН (ҮРГЭЛЖЛЭЛ)

МИК Холдинг ХК-ийн охин компаниудын (МИК) гаргасан давуу эрхтэй Ипотекийн зээлээр барьцаалагдсан бонд (ИЗББ)

Банк нь 2014, 2015 онуудад МИК болон дотоодын банкуудтай Орон сууцны зээлийн санхүүжилтийн гурвалсан гэрээ байгуулсан. Уг гэрээний хүрээнд Банк дотоодын банкуудад олгосон бага хүүтэй зээлийн төлбөрт МИК-ийн гаргасан давуу эрхтэй ИЗББ-г хүлээн авсан. Уг бонд нь 20 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй.

МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт

“МИК Холдинг” ХК нь 2015 оны 12 сарын 24-нд Монголын хөрөнгийн биржид нэгж хувьцааныхаа үнийг 12,000 төгрөгөөр бүртгүүлсэн. Банкны өмчийн хөрөнгө оруулалт болох 421,241 ширхэг хувьцаа нь (нийт хувьцааны 2.03 хувь) 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5,055 сая төгрөгөөр үнэлэгдсэн (2014: 402,000 ширхэг хувьцаа 428 сая төгрөгийн өртөгтэй). Үнэт цаасны дахин үнэлгээний олз, гарз нь өөрийн хөрөнгөд сангаар бүртгэгдсэн.

Хөгжлийн банкны үнэт цаас

Хөгжлийн Банкны үнэт цааснууд нь Хөгжлийн банкнаас гаргасан 3 өрийн бичиг юм. Үнэт цаасуудын нийт нэрлэсэн үнэ 133,749 сая төгрөг ба жилийн 4 хувийн хүүтэй, 2018 болон 2021 онуудад хугацаа нь дуусах нөхцөлтэй. Хүүгийн төлбөр хагас жил тутамд төлөгдөнө.

Эдгээр үнэт цаасуудыг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ нь 105,146 сая төгрөг байсан ба тэдгээрийн нэрлэсэн болон бодит үнэ цэнийн зөрүү 28,603 сая төгрөгийг тайлант жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн болно.

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэт цаасууд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн ба Тодруулга 35 ба 39-өөс бодит үнэ цэнэ, тайлант хугацааны дараах үйл явдлуудын толилуулгыг харна уу.

Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй энгийн хувьцаа нь Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк болон Монголын банкуудын холбоонд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгө оруулалтуудыг өртгөөр нь бүртгэсэн. Эдгээр хөрөнгө оруулалтуудад зах зээл байхгүй ба Банк эдгээрийг урт хугацаагаар эзэмших төлөвтэй байна. Санхүүжигч талын санхүүгийн мэдээлэлд үндэслэн удирдлага 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр энэхүү хөрөнгө оруулалтуудад үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг байхгүй гэж үзэж байна.

16. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЛҮҮД

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	827,134	944,686
Дотоодын банкууд - төгрөгийн	400,035	521,871
Дотоодын банкууд - ам.долларын	100,852	–
	<u>1,328,021</u>	<u>1,466,557</u>

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк

Банк Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжаараа “Автомат хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 250,000 ам.доллараас давсан дүнг Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээнд (буцаан худалдан авах репо) хөрөнгө оруулдаг. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 414.4 сая ам.доллартэй тэнцүү, жилийн 0.36 хувийн хүүтэй байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь нэг хоногийн хугацаатай ба хүүг Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкнаас тогтоодог.

Дотоодын банкууд

Дотоодын банкуудтай байгуулсан “Төгрөгийн” урвуу буцаан худалдан авах хэлцлүүд нь Төв банкны үнэт цаас (Тодруулга 25) болон Засгийн газрын үнэт цаасуудаар баталгаажсан богино болон урт хугацаат зээлийг илэрхийлдэг. Энэхүү хэрэглүүрүүд нь 7 хоногийн хугацаатай, жилийн Бодлогын хүү дээр 2% нэмсэн хүүтэй (2015 болон 2014 оны жилийн эцсээр харгалзан 15% болон 14% хувиар тодорхойлогдож байсан). Эдгээр дүнгүүд нь хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтгүй.

Дотоодын банкуудтай байгуулсан “Ам долларын” урвуу буцаан худалдан авах хэлцэл нь 6 сарын хугацаатай, жилийн 5 хувийн хүүтэй.

17. АЛТ, ҮНЭТ МЕТАЛ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Бодит үнэ цэнээр		
Мөнгөжсөн алт	153,097	207,066
Мөнгөжсөн мөнгө	343	116
Өртгөөр		
Худалдан авсан алт	258,366	121,154
Цэвэршүүлэхээр ачуулсан алт	2,603	1,321
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	5,743	4,302
	<u>420,152</u>	<u>333,959</u>

Мөнгөжсөн алт нь Английн Төв банк болон Нова Скотиа банкинд байршдаг. Бусад үнэт метал (мөнгөжөөгүй алт, мөнгө, бусад хольц метал болон гулдмай, мөнгөний хүдэр), зоос болон түүх соёлын үнэт зүйлсийг Банкинд хадгалдаг.

18. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд нь дотоод болон гадаадын банкуудтай байгуулсан гадаад валютын своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийг илэрхийлдэг.

Доорх хүснэгт нь хөрөнгө ба өр төлбөрөөр бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамт харуулж байна. Нэрлэсэн үнэ нь өссөн дүнгээрээ үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн суурь хөрөнгийн дүн байх бөгөөд үндсэн хүү эсвэл хүүгийн индексээс шалтгаалан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд өөрчлөлт орно. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх дуусаагүй гүйлгээний хэмжээг харуулах боловч зах зээлийн болон зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлэхгүй.

	Нэрлэсэн	Бодит үнэ цэнэ		Нэрлэсэн	Бодит үнэ цэнэ	
	Үнэ	Хөрөнгө	Өр төлбөр	Үнэ	Хөрөнгө	Өр төлбөр
	2015	2015	2015	2014	2014	2014
	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Форвард	–	–	–	202,175	–	20,177
Своп	2,726,842	8,974	424,995	1,289,766	3,264	69,533
	2,726,842	8,974	424,995	1,491,941	3,264	89,710

Хэлцлийн эхний өдөр үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд нь маш бага эсвэл огт шилжүүлэг шаардахгүй ба ихэвчлэн хоёр талын амлалтын солилцоо хийгддэг. Хэдий тийм ч эдгээр санхүүгийн хэрэглүүрүүд нь хөшүүргийн өндөр зэргийг давтамжтай шаардах ба маш хувьсамтгай байдаг. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлцлийн хөрөнгө, түвшин болон индексийн үнэлгээн дэх харьцангуй бага хэмжээний өөрчлөлт ч Банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй байдаг.

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр эдгээр үүсмэл хэрэглүүрүүдийн дуусах хугацаа, жигнэсэн дундаж форвард ханш дараах байдалтай байв.

		Жигнэсэн дундаж форвард ханш 2015	Дуусах хугацаа	Жигнэсэн дундаж форвард ханш 2014	Дуусах хугацаа
Форвард					
ам.долл/төг	Худалдах	–	–	1,532.00 төг	1-6 сар
Своп					
ам.долл/төг	Худалдан авах	2,022.47 төг	1 жил хүртэл	1,793.74 төг	3 сар хүртэл
ам.долл/төг	Худалдах	2,084.39 төг	6 сар хүртэл	1,870.42 төг	3 сар хүртэл
ам.долл/төг	Худалдах	1,987.71 төг	5 жил хүртэл	2,033.16 төг	1-5 жил
юань/төг	Худалдах	310.21 төг	6 сар хүртэл	291.79 төг	1-6 сар
юань/ам.долл	Худалдах	6.5614 юань	1 сар хүртэл	6.1232 юань	1-10 сар

19. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Сангийн яамны үнэт цаас (хорогдуулсан өртгөөрөө)	199,787	202,404
Хуримтлагдсан хүүгийн авлага	2,431	2,424
	<u>202,218</u>	<u>204,828</u>

Банк Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч захаас урамшуулалтай үнээр худалдаж авсан. Үнэт цаасны нэрлэсэн үнэ 195 сая төгрөг ба жилийн 9.6-аас 10.3 хувийн хүүтэй, 2016, 2018 онуудад хугацаа нь дуусах нөхцөлтэй.

20. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл	882,451	2,060,974
Татан буугдсан “Анодбанк” ХК-д олгосон зээл (Тодруулга 21)	–	73,812
Бусад зээл	303,069	24,971
	<u>1,185,520</u>	<u>2,159,757</u>
Хасах нь: Үнэ цэнэ бууралтын алдагдлын сан	–	(73,812)
	<u>1,185,520</u>	<u>2,085,945</u>

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

Банк нь 2012 оны 11 дүгээр сараас эхлэн Засгийн газрын “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд төгрөгийн зээлийг дотоодын банкуудад сонгогдсон салбарт (шатахуун, хүнс, барилга гэх мэт) үйл ажиллагаа явуулж буй дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад дамжуулан зээлдүүлүүлэхээр олгосон.

Эдгээр зээлийн нөхцөл болон хугацааг Засгийн газар тодорхойлдог ба оролцогч банкууд бие даан зээлийн нөхцөлийг тодорхойлох боломжгүй. Түүнчлэн оролцох аж ахуйн нэгж байгууллагуудыг Засгийн газар сонгодог ба сонгогдсон аж ахуй нэгж байгууллагууд аль ч дотоодын банкуудаар дамжуулан тус зээлийг (Монголбанк дахин санхүүжүүлсэн) авч болно. Засгийн газрын нөхцөлийн дагуу банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин жилийн 0.5 хувиас 7 хувийн хооронд байна.

МИК болон дотоодын банкуудтай байгуулсан “Орон сууцны зээлийн санхүүжилтийн гэрээ”-ний дагуу Банк дотоодын банкуудад “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээлийн төлбөрт МИК-ийн гаргасан давуу эрхтэй ИЗББ-г хүлээн авсан. (Тодруулга 15-г үзнэ үү).

20. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл (Үргэлжлэл)

Улсын Их Хурлын 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дугаар тогтоолын дагуу Банк 2014 оны 12 дугаар сараас “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-өөс үе шаттай гарч эхэлсэн ба дотоодын банкуудад уг хөтөлбөрийн хүрээнд нэмэлт зээл, үүсмэл санхүүгийн үүсмэл хэрэглүүр олгохоо зогсоосон байна. 2015 онд Банк уг хөтөлбөрийн хүрээнд хүнсний үнэ тогтворжуулах, орон сууцны үнэ тогтворжуулах, орон сууцны зээлийн санхүүжилт болон гурилын үнэ тогтворжуулах гэсэн 4 төрлийн хөтөлбөрт зээл олгосон.

Татан буугдсан “Анодбанк” ХК-д олгосон зээл

Татан буугдсан “Анодбанк” ХК-ийн эрх хүлээн авагч татан буугдаж, үүрэг хариуцлагыг Банкны Авлага барагдуулах алба хүлээн авсантай холбогдуулан 2015 оны 6 дугаар сард 73.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй татан буугдсан “Анодбанк” ХК-ийн зээлийг үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хамт “Дотоодын банкинд олгосон зээл” данснаас “Бусад хөрөнгө” дансанд шилжүүлэн бүртгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 21-ээс харна уу.

Төгрөгөөр олгосон зээл

“Бусад зээл”-ийн нэг хэсэг болох төгрөгөөр олгосон зээлд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 3,389 сая төгрөгийн (2014 онд 1,188 сая төгрөг) зээл, Герман улсын Засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 7,393 сая төгрөгийн (2014 онд 5,759 сая төгрөг) зээл болон 285,000 сая төгрөгийн (2014 онд 9,000 сая төгрөг) барьцаат зээлүүд тус тус багтаж байна.

АХБ-ны хөтөлбөрийг зээлийг цааш нь аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлэхээр дотоодын банкуудад олгосон.

Зээл нь шинээр ажлын байр бий болгох, мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх зорилгоор олгогдсон. Зээл нь жилийн 10 хувийн хүүтэй ба эргэн төлөлтийн хугацаа нь олгосон өдрөөс хамааран ялгаатай байна. Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн банкны данснаас зээлийг шууд төлүүлэх эрхтэй.

Гадаад валютаар олгосон зээл

“Бусад зээл”-ийн нөгөө хэсэг болох валютаар олгосон зээлийн дийлэнх хувийг жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон 6,519 сая төгрөгийн (2014 онд 8,234 сая төгрөг) зээл, банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах зорилгоор олгосон 751 сая төгрөгийн (2014 онд 754 сая төгрөг) зээл тус тус бүрдүүлж байна.

20. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гадаад валютаар олгосон зээл (Үргэлжлэл)

Герман улсын Засгийн газраас Монгол улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон зээл нь бие даасан хоёр тусдаа КФВ хөтөлбөрөөр хэрэгжиж байна. Эдгээр зээл нь жилийн 1.25-1.75 хувийн хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажуулж.

Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Банк нь зээлийн гэрээний дагуу зээл төлөгдөх хугацаа болмогц, тухайн банкны Монголбанк дахь харилцах данснаас шууд төлүүлэх эрхтэй. Эдгээр зээлийн хөтөлбөрүүд болон эдгээртэй холбоотой Банкны Сангийн яаманд төлөх өглөгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 26-аас харна уу.

Дотоодын банкны ажилчдын ур чадварыг дээшлүүлж, банкуудын програм хангамжийг сайжруулах зорилготой зээл нь Монгол улс ба Азийн хөгжлийн банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) лимитед компанийн зохион байгуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон. Энэхүү зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь 14 жил.

2015 оны турш хийгдсэн зээлийн үнэ цэнэ бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөнийг доор харуулав.

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
01 дүгээр сарын 01-ний байдлаар	73,812	77,630
Бусад хөрөнгө рүү шилжүүлсэн (Тодруулга 21)	(73,662)	–
Сангийн буцаалт (Тодруулга 10)	(150)	(3,818)
12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>–</u>	<u>73,812</u>

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээлүүд, төгрөгөөр болон гадаад валютаар олгосон зээлүүдийн хувьд үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илрээгүй тул үнэ цэнийн бууралтын алдагдлын сан байгуулаагүй болно.

Барьцаат зээлүүдээс бусад дотоодын банкуудад олгосон төгрөгийн зээлүүдийн хувьд барьцаагүй. Барьцаат зээлүүдийн хувьд Засгийн газрын үнэт цаас болон тухайн банкны хэвийн зээлийн багцаар баталгаажсан.

21. БУСАД ХӨРӨНГӨ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Бусад санхүүгийн хөрөнгө		
Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага	204,911	204,911
Татан буугдсан “Анодбанк” ХК-иас хүлээн авсан хөрөнгө	67,646	—
Бусад компаниудаас авах авлага	52,657	50,228
Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага	17,450	16,485
Өрийн бичгээрх авлага	356,975	537,584
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(222,757)	(151,626)
	<u>476,882</u>	<u>657,582</u>
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж гарсан зардал	149	151
Бусад	618	816
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(236)	(397)
	<u>531</u>	<u>570</u>
	<u>477,413</u>	<u>658,152</u>

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-аас авах авлага

ХДК-иас авах авлага нь 119.9 тэрбум төгрөгийн зээл болон 85.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгээс бүрдэнэ. 119.9 тэрбум төгрөгийн зээл нь 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр бүрэн төлөгдөх нөхцөлтэй ба 85.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг нь “Төрийн банк” ХХК-ийн хувьчлалын орлогоос 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр эргэн төлөгдөх нөхцөлтэй байсан. 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр “Төрийн банк” ХХК нь хувьчлагдаагүй ба санхүүгийн дэмжлэг нь эргэн төлөгдөөгүй байна. 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүйн улмаас Банк нийт дүнгээр нь буюу 85.0 тэрбум төгрөгөөр үнэ цэнийн бууралтын сан байгуулсан (Тодруулга 2.4).

Татан буугдсан “Анодбанк” ХК-иас хүлээн авсан хөрөнгө

Татан буугдсан “Анодбанк” ХК-ийн Эрх хүлээн авагчийн үүргийг Банкны авлага барагдуулах алба хүлээн авсан тул Банк 73.8 тэрбум төгрөгийн дансны үнэтэй хөрөнгийг шилжүүлэн авсан бөгөөд уг хөрөнгийг, үнэ цэнийн бууралтын сангийн хамт 2015 онд “Дотоодын банкинд олгосон зээл” данснаас “Бусад хөрөнгө” дансанд шилжүүлэн бүртгэсэн. Эдгээр хөрөнгөд татан буугдсан “Анодбанк” ХК-ийн олгосон зээлийн багцууд болон бусад хөрөнгүүд багтсан болно.

Бусад компаниудаас авах авлага

Бусад компаниудаас авах авлагад өмнөх жилүүдэд Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах авлага багтана. Эдгээр авлагын дүн нь 37,525 сая төгрөг (2014 онд 35,534 сая төгрөг) ба авлагуудыг найдваргүйд тооцон үнэ цэнийн бууралтын алдагдлын санг бүрэн байгуулсан.

21. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад компаниудаас авах авлага (Үргэлжлэл)

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бусад аж ахуйн нэгжүүдээс авах авлагын үлдэгдэл 15,080 сая төгрөг (2014 онд 14,607 сая төгрөг) байгаа ба үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн санг бүрэн байгуулсан болно. Эдгээр авлагад орсон хөдөлгөөн нь зөвхөн гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн болно.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлагыг бүхэлд нь эргэн төлөгдөхгүй гэж үзэн бүрэн сан байгуулсан нь тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.

Өрийн бичгээрх авлага

Өрийн бичгээрх авлага нь дотоодын компаниудаас гаргасан доорх өрийн бичгүүдийг илэрхийлж байна. Үүнд:

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк 350.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй дотоодын гурван компаниас гаргасан өрийн бичгүүдийг эзэмшиж байна. Эдгээр өрийн бичгүүд нь 5-6 жилийн хугацаатай, жилийн 7.0-21.0 хувийн хүүтэй байна. Өрийн бичгийн гэрээнүүд нь тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд (жишээ нь, өрийн бичиг гаргагч нь тодорхой хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт татсан) хүү буурах нөхцөлтэйгээр хийгдсэн. Банкны удирдлага болон дотоод хуульчид эдгээр гүйлгээнүүд нь Төв банк(Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хуулийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байгаа.

2015 оны 4 дүгээр сард өрийн бичиг гаргагч дотоодын компаниуд нь хүү бууруулах нөхцөлийг хангасан ба боломжит хамгийн бага хүүгийн хувь болох жилийн 7.0-7.5 хувийн хүүтэй болсон.

2015 оны 7 дугаар сарын 17-нд Банк Сангийн яамнаас гаргасан нийт 4.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тэг (0) хувийн хүүтэй, 2015 оны 12 дугаар сарын 31-нд хугацаа нь дуусах өрийн бичгүүдийг авсан. Эдгээр өрийн бичгүүд нь 2016 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр бүрэн төлөгдөж дууссан.

Хөгжлийн банкны 177.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй өрийн бичиг 2015 оны 2 дугаар сард хугацаа нь дууссан бөгөөд тухайн жилдээ хугацаа нь дуусах Засгийн газрын бондоор эргэн төлөгдсөн.

Бусад санхүүгийн бус хөрөнгө

Бусад санхүүгийн бус хөрөнгүүд нь ихэвчлэн урьдчилгаа төлбөр, ажилтнуудад олгосон урьдчилгаа, хангамжийн материал, бичиг хэргийн материал болон хураан авсан хөрөнгүүдээс бүрдэнэ.

21. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан

2014 ба 2015 оны турш хийгдсэн бусад хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Бусад санхүүгийн хөрөнгө		
01 дүгээр сарын 01-ний байдлаар	151,626	59,282
Дотоодын банкуудад олгосон зээлээс шилжиж ирсэн татан буугдсан “Анодбанк” ХХК-иас хүлээн авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сан (Тодруулга 20)	73,662	–
Гадаад валютаар илэрхийлэгдсэн сангийн ханшийн хөрвүүлэг	3,550	7,458
Үнэ цэнийн бууралтын алдагдал (Тодруулга 10)	57	85,000
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн буцаалт (Тодруулга 10)	(6,138)	(114)
12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>222,757</u>	<u>151,626</u>
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
01 дүгээр сарын 01-ний байдлаар	397	229
Гадаад валютаар илэрхийлэгдсэн сангийн ханшийн хөрвүүлэг	4	10
Үнэ цэнийн бууралтын алдагдал (Тодруулга 10)	–	158
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн буцаалт (Тодруулга 10)	(165)	–
12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>236</u>	<u>397</u>

2014 ба 2015 оны турш хийгдсэн татан буугдсан “Анодбанк” ХК-иас авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
01 дүгээр сарын 01-ний байдлаар	73,812	77,630
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн буцаалт	(6,166)	(3,818)
12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>67,646</u>	<u>73,812</u>

22. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ХӨРӨНГӨ

Банкны борлуулах үе шатанд байгаа тодорхой хөрөнгүүд болон хураан авсан хөрөнгүүдийг дор харуулав:

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
01 дүгээр сарын 01-ний байдлаар	450	–
Нэмэх нь: Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө рүү нэмж ангилсан	4,215	450
12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>4,665</u>	<u>450</u>

Банк эдгээр хөрөнгүүдийг дуудлага худалдаагаар борлуулахаар төлөвлөж байгаа бөгөөд дуудлага худалдаа 2016 оны 6 дугаар сард зохион байгуулагдана. Хөрөнгүүдийг дансны үнээр нь бүртгэсэн ба энэ нь дансны үнэ болон бодит үнэ цэнээс худалдах зардлыг хассан дүнгийн бага нь юм.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Барилга байшин	Дуусаагүй барилга	Компьютер, тоног төхөөрөмж	Нийт үндсэн хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт
2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Өртөг эсвэл дахин үнэлгээгээр						
2015 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	47,338	38	8,361	55,737	2,267	58,004
Нэмэгдсэн	452	1,872	1,520	3,844	131	3,975
Худалдан борлуулсан	(1,489)	–	(817)	(2,306)	(5)	(2,311)
Данснаас хассан	–	–	(69)	(69)	–	(69)
Дахин ангилал	32	(363)	331	–	–	–
Шилжүүлэг	(51)	–	51	–	–	–
2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	46,282	1,547	9,377	57,206	2,393	59,599
Хуримтлагдсан элэгдэл						
2015 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	25,113	–	3,788	28,901	1,713	30,614
Тухайн жилийн элэгдлийн зардал	863	–	1,280	2,143	254	2,397
Худалдан борлуулсан	(1,311)	–	(812)	(2,123)	(5)	(2,128)
Данснаас хассан	–	–	(57)	(57)	–	(57)
Шилжүүлэг	–	–	–	–	–	–
2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	24,665	–	4,199	28,864	1,962	30,826
Дансны цэвэр үнэ	21,617	1,547	5,178	28,342	431	28,773

23. ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Барилга байшин	Дуусаагүй барилга	Компьютер, тоног төхөөрөмж	Нийт үндсэн хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт
2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Өртөг эсвэл дахин үнэлгээгээр						
2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	46,732	759	8,873	56,364	2,301	58,665
Нэмэгдсэн	11	1,455	280	1,746	47	1,793
Худалдан борлуулсан	(15)	–	(1,598)	(1,613)	(81)	(1,694)
Данснаас хассан	(27)	–	(124)	(151)	–	(151)
Шилжүүлэг	(609)	–	–	(609)	–	(609)
Дахин ангилал	1,246	(2,176)	930	–	–	–
2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	47,338	38	8,361	55,737	2,267	58,004
Хуримтлагдсан элэгдэл						
2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	24,426	–	4,250	28,676	1,543	30,219
Тухайн жилийн элэгдлийн зардал	1,020	–	1,205	2,225	251	2,476
Худалдан борлуулсан	(13)	–	(1,577)	(1,590)	(81)	(1,671)
Данснаас хассан	(25)	–	(90)	(115)	–	(115)
Дахин ангилал	(295)	–	–	(295)	–	(295)
2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	25,113	–	3,788	28,901	1,713	30,614
Дансны цэвэр үнэ	22,225	38	4,573	26,836	554	27,390

23. ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хамгийн сүүлийн үнэлгээг хараат бус үнэлгээч болох “Үнэлгээ ба төслийн компаниудын консорциум” 2013 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр гүйцэтгэсэн.

Эдгээр барилгуудыг өртгөөр нь бүртгэсэн байсан бол 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэдгээрийн дансны үнэ 13,989 сая төгрөг (2014 онд 14,281 сая төгрөг) байх байсан.

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ямар нэг үндсэн болон биет бус хөрөнгө зээлийн барьцаанд байгаагүй.

24. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	804,072	892,389
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(97,430)	(82,743)
	<u>706,642</u>	<u>809,646</u>
Гүйлгээнд гаргасан зоосон төгрөг	14	11
	<u>706,656</u>	<u>809,657</u>

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө

	Эхний үлдэгдэл 2015 сая төгрөг	Өсөлт 2015 сая төгрөг	Бууралт 2015 сая төгрөг	Эцсийн үлдэгдэл 2015 сая төгрөг
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	892,389	1,963,982	(2,052,299)	804,072
Гүйлгээнд гаргасан зоосон төгрөг	<u>11</u>	<u>3</u>	<u>–</u>	<u>14</u>
	<u>892,400</u>	<u>1,963,985</u>	<u>(2,052,299)</u>	<u>804,086</u>
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	<u>(82,743)</u>	<u>(2,012,426)</u>	<u>1,997,739</u>	<u>(97,430)</u>
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	<u>809,657</u>	<u>(48,441)</u>	<u>(54,560)</u>	<u>706,656</u>

25. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Үнэт цаасны өглөг	<u>1,024,581</u>	<u>853,781</u>

Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаас юм. Эдгээр үнэт цаас нь 7-28 хоногийн хугацаатай бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүүгийн түвшин нь жилийн 13 хувь (2014 онд: 12 хувь) байна.

26. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ӨР ТӨЛБӨР

	2015	2014
	сая төгрөг	сая төгрөг
Сангийн яаманд төлөх зээлийн өр төлбөр		
- Германы Засгийн газар (КФВ)	14,121	15,488
- Азийн хөгжлийн банк (АХБ)	8,084	8,284
- Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)	6,678	7,004
Сангийн яамны харилцах, хадгаламж	<u>673,573</u>	<u>767,873</u>
	<u>702,456</u>	<u>798,649</u>

Сангийн яамны дансууд

Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Сангийн яамны төрөл бүрийн харилцах дансууд бөгөөд хугацаагүй, хүүгүй болно.

Олон улсын байгууллагаас авсан зээллэгтэй холбоотой Сангийн яаманд төлөх өр төлбөр

Эдгээр өр төлбөр нь Монгол улсын Засгийн газраас “КФВ” (Герман улсын Засгийн газрыг төлөөлж), Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх) болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-тай байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Гэрээнд Монгол улсын Сангийн яам нь санхүүгийн төлөөлөгчөөр Банк нь төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд КФВ-аас авсан зээл нь бие даасан хоёр хөтөлбөртэй ба 1995 болон 2003 оноос тус тус хэрэгжиж эхэлсэн. Эдгээр зээлүүд нь еврогоор олгогдсон бөгөөд жилийн 0.75 хувийн хүүтэй, 30 жилийн хугацаатай. Эхний болон дараагийн хөтөлбөрийн эргэн төлөлтүүд 2005 болон 2012 оноос эхлэн төлөгдөж эхэлсэн.

АХБ-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээлүүд нь жилийн 1 хувийн (2014 онд: 1 хувь) хүүтэй ба дуусгавар хугацаа нь 27- 30 жил байна.

26. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Олон улсын байгууллагаас авсан зээллэгтэй холбоотой Сангийн яаманд төлөх өр төлбөр (Үргэлжлэл)

Сангийн яам нь Монгол улсын Засгийн газрыг төлөөлөн санхүүгийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэдэг учир Банк КФВ болон АХБ-ны төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг дотоодын банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр дотоодын банкууд нь КФВ болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийг эцсийн хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хариуцна.

Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь КФВ болон АХБ-ны гэрээний нөхцөлтэй ижил нөхцөлтэйгээр Сангийн яамнаас эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, КФВ, АХБ болон Сангийн яамны хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 20-д харуулав. Сангийн яаманд өгөх эдгээр өглөг болон дотоодын банкуудад олгосон зээлийн талаарх Банкны Удирдлагын үнэлэмжийг Тодруулга 2.4-с харна уу.

ОУХА-ийн хувийн хэвшлийг хөгжүүлэх болон санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төслийн хүрээнд Монгол улсын Засгийн газарт олгосон зээлийг Банк Сангийн яамнаас дамжуулан авсан ба зээл нь жилийн 1 болон 3 хувийн хүүтэй.

27. ДОТООДЫН БАНКУУДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Харилцах дансдууд:		
- төгрөгөөр	1,225,029	1,098,540
- валютаар	533,326	1,501,042
Богино хугацаат хадгаламж	—	127,500
Гадаад валютын хугацаат хадгаламж	60,630	76,380
	<u>1,818,985</u>	<u>2,803,462</u>

Харилцах дансны дүн нь дотоодын банкуудаас Банкинд заавал байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжаас бүрдэнэ. Заавал байлгах нөөцийг банкууд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд тодорхой хувиар тооцож тогтооно.

2014 оны 12 дугаар сарын 31-нээр үлдэгдэлтэй байсан богино хугацаат хадгаламж нь дотоодын банкуудын байршуулсан жилийн 10 хувийн хүүтэй овернайт хадгаламж байсан.

Гадаад валютын хугацаат хадгаламж нь 371 хоногийн хугацаатай, жилийн 6.532 (2014: 5.571) хувийн хүүтэй дотоодын банкуудын байршуулсан ам.долларын хадгаламжийг илэрхийлнэ.

28. ГАДААД ӨР ТӨЛБӨР

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Барьцаагүй		
Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан юанийн санхүүжилт	3,550,766	2,763,903
Токио Мицүбиши Юү Эф Жи Сингапур банкнаас авсан алтны урьдчилгаа санхүүжилт	239,554	90,582
Олон улсын валютын сан ("ОУВС")		
- Зээлжих тусгай эрхийн хуваарилалт (ЗТЭ)	135,180	133,190
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	125	118
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	34	34
Дэлхийн банкны харилцах данс	110	60
АХБ-ны харилцах данс	8	1
	<u>3,925,777</u>	<u>2,987,888</u>

Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан юанийн санхүүжилт

Энэхүү үлдэгдэл нь Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан 3 сараас 12 сарын хугацаатай юанийн санхүүжилт бөгөөд Банк дотоодын банкуудыг юаниар санхүүжүүлэхэд ашигладаг. Хүү нь “200” үндсэн нэгж дээр Шанхай-Интер банкны санал болгосон хүүгийн түвшинг (“SHIBOR”) нэмсэнтэй тэнцүү.

Токио Мицүбиши Юү Эф Жи Сингапур банкнаас авсан алтны урьдчилгаа санхүүжилт

Энэхүү үлдэгдэл нь алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээний хүрээнд Токио Мицүбиши Юү Эф Жи Сингапур банкнаас авсан 1 жилийн хугацаатай алтны урьдчилгаа санхүүжилт бөгөөд Банк нь дотоодын алт олборлогч иргэд, аж ахуйн нэгжээс алт худалдан авахад уг санхүүжилтийг ашигладаг. Хүү нь “310” үндсэн нэгж дээр Лондон-Интер банкны санал болгосон түвшинг (“LIBOR”) нэмсэнтэй тэнцүү (2014: LIBOR+300 үндсэн нэгж).

Зээлжих тусгай эрх (ЗТЭ)-ийн хуваарилалт

ОУВС-ын гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилсан. Энэ хуваарилалт нь Банкны ОУВС-д өгөх өр төлбөрийг илэрхийлэх ба үүний зэрэгцээ ОУВС-ийн ЗТЭ-ийн хөрөнгийн дансыг Тодруулга 14-өөс харна уу. Хуваарилалтын цэвэр хуримтлал нь 135,180 сая төгрөг (2014 онд 133,190 сая төгрөг) буюу 48.757 сая ЗТЭ (2014 онд 48.757 сая ЗТЭ)-тэй тэнцүү байна.

Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн банк болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-т оруулсан хувь хөрөнгө юм.

29. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Бусад санхүүгийн өр төлбөр		
Дотоодын банкны дүрмийн сангийн эх үүсвэрт түр төвлөрүүлсэн хөрөнгө	4,015	9,391
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж	7,370	8,758
Бусад өр төлбөр	10,314	9,055
Бусад өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	8,595	8,516
Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан	48,351	45,751
	<u>78,645</u>	<u>81,471</u>

Дотоодын банкны дүрмийн сангийн эх үүсвэрт түр төвлөрүүлсэн хөрөнгө

Дотоодын банкны дүрмийн сангийн эх үүсвэрт түр төвлөрүүлсэн хөрөнгө нь Монгол улсын дотоодын банкны дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой нээсэн дансууд юм. Эдгээр дансуудыг тухайн дотоодын банкуудад хөрөнгө оруулалт хийхээс өөр зорилгоор ашиглахгүй.

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь төрийн байгууллагууд, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв, Хадгаламжийн даатгалын корпорацийн харилцах данснудаас бүрдэнэ.

Нийгмийн хөгжлийн сан

Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг өөрсдийн ажилтнуудын ажлын болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилтанд тэтгэмж, тусламж олгох, ажлын үзүүлэлтээр шагнах, ажилтны нийгмийн байдлыг хангах үүднээс орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Банкны Удирдлага 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай гэж үзсэн.

Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан

Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан нь 2008 онд үүссэн шийдэгдээгүй хэрэгтэй холбоотой үүссэн. Швейцар болон Герман улсуудад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагатай 2008 оноос хойш хийсэн аккредитивийн гэрээтэй холбоотойгоор шүүхэд нэхэмжилж, шүүх үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа.

29. БУСАД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан (Үргэлжлэл)

Банк энэ шүүхэд аккредитивийн гэрээний дагуу өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд байр сууриа баттай хамгаалж байгаа хэдий ч 2009 онд нийт дүнгээр (хүүг оруулан) нь эрсдэлийн сан байгуулсан. 2014 болон 2015 оны туршид гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөнөөс гадна нөөцийн санд өөрчлөлт ороогүй. Эдгээр аккредитивтэй холбогдуулан Америкийн нэгдсэн улсын өмнөд Флоридагийн дүүргийн шүүхэд Банк залилан, гэрээний зөрчил гэх мэт хууль зөрчсөн үндэслэлээр тодорхой хувь хүн болон байгууллагуудыг шүүхэд дуудан зарга үүсгээд байгаа. Уг хувь хүн болон байгууллагаас нэхэмжилж буй дүн нь Банкны төлж болзошгүй дээр дурдсан өр төлбөрөөс мэдэгдэхүйц хэмжээгээр давж байгаа юм. Хэрэг Банкны хувьд нааштай шийдэгдэх хандлагатай байгаа хэдий ч хариуцагчид авлагыг бүрэн хэмжээгээр барагдуулна гэсэн хангалттай баталгаа байхгүй байна. Тиймээс Банк санхүүгийн тайланд авлага хүлээн зөвшөөрөөгүй боловч нэхэмжилсэн төлбөрөө барагдуулахаар тууштай ажиллаж байна.

30. ДҮРМИЙН САН

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Дүрмийн сан	<u>5,000</u>	<u>5,000</u>

Банкны дүрмийн сан нь Банкны капиталыг илэрхийлэх ба үүнийг Монгол улсын төр бүрэн эзэмшдэг.

31. БУСАД САН

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн сан

Энэ сан нь борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдээс бүрддэг.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан

Энэ сан нь Банкны барилга, байгууламжийн дахин үнэлгээнээс үүссэн олзоос бүрддэг.

Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн сан

Энэ санг гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, өр төлбөрүүдийн ханшийн тэгшитгэлээс үүссэн бодит бус олз, гарзыг бүртгэхэд ашигладаг.

Үнэт металын дахин үнэлгээний сан

Энэ дансыг нь Банкны эзэмшилд байгаа мөнгөжсөн алтны бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн бодит бус олз, гарзыг бүртгэхэд ашигладаг.

31. БУСАД САН (ҮРГЭЛЖЛЭЛ)

2014 ба 2015 оны бусад сангийн хөдөлгөөнийг доор харуулав.

	Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн сан сая төгрөг	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан сая төгрөг	Үнэт металын дахин үнэлгээний сан сая төгрөг	Нийт сая төгрөг
2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	(52)	12,051	13,059	25,058
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал	(271)	–	–	(271)
Борлуулах үед орлогын тайланруу шилжүүлсэн	103	–	–	103
Хуримтладсан алдагдалд шилжүүлсэн	–	–	(6,873)	(6,873)
Дахин үнэлгээний нөөц	–	(2)	–	(2)
2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>(220)</u>	<u>12,049</u>	<u>6,186</u>	<u>18,015</u>
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал	3,211	–	–	3,211
Борлуулах үед орлогын тайлан руу шилжүүлсэн	(65)	–	–	(65)
Дахин үнэлгээний нөөц	–	(141)	–	(141)
Хуримтладсан алдагдалд шилжүүлсэн	–	–	(4,242)	(4,242)
2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>2,926</u>	<u>11,908</u>	<u>1,944</u>	<u>16,778</u>

2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-нээр гадаад валютын дахин үнэлгээний сан байхгүй.

32. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг.

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Болзошгүй өр төлбөр		
Экспортын аккредитивүүд	(411,390)	(106,354)
Өрийн бичиг	–	(31,669)
Үүрэг		
Хятадын ардын банктай хиисэн своп хэлцлийн дагуу авах ашиглаагүй санхүүжилтийн эх үүсвэр	1,076,390	1,821,420
Хятадын ардын банктай хиисэн своп хэлцлийн дагуу өгөх ашиглаагүй санхүүжилтийн эх үүсвэр	(4,500,000)	(4,500,000)
Хөрөнгийн үүрэг	(12)	(198)
	<u>(3,835,012)</u>	<u>(2,816,801)</u>

Экспортын аккредитивүүд

Экспортын аккредитив нь Монгол улсын Засгийн газарт экспортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Экспортын аккредитивээр Банк Монгол улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс тэдгээрт болон Засгийн газрын хүсэлтээр бусад байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн ба бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдүүдэд төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Банкны Удирдлага 2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аккредитив, зээлийн шугамаарх үүрэг хариуцлагын бодит үнэ цэнийг материаллаг бус хэмээн дүгнэсэн байна. Ашиглагдаагүй байгаа зээлийн шугам болон аккредитивийн гэрээт үлдэгдэл нь ирээдүйн бэлэн мөнгөний шаардлагыг бий болгохгүй. Учир нь эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлийн гэрээ

Банк нь 2011 оны 5 дугаар сард Хятадын ардын банктай “Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлцэл”-ийн гэрээ байгуулсан ба гэрээг 2014 оны 8 дугаар сард шинэчлэн баталсан. Төв банкууд санхүүгийн зах зээлийн тогтвортой байлдыг хангах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах, хоёр улсын эдийн засгийн хөгжлийн төлөө хоёр орны худалдааг дэмжих зорилгоор энэхүү гэрээг байгуулсан.

Уг гэрээний дагуу Хятадын ардын банк (ХАБ) ба Банк нь юаниар төгрөг эсвэл төгрөгөөр юань худалдах, худалдан авах болон дараа нь түүнийг буцаан худалдах, худалдан авах байдлаар гүйлгээ хийж болно.

32. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлийн гэрээ (Үргэлжлэл)

Эдгээр зорилгын хүрээнд Төв банк бүр нөгөө талдаа зориулан өөрийн орныхоо мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх хүү тооцдоггүй тусгай дансыг нээсэн. Өөрөөр хэлбэл ХАБ юанийн дансыг Банкинд, Банк төгрөгийн дансыг ХАБ-д зориулан тус тус нээсэн.

Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа нь 12 сар хүртэл байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөөгөөсөө авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн дээд хэмжээ нь Банкны хувьд гэрээний дүн болох 15 тэрбум юань (2014 онд 15 тэрбум юань), ХАБ-ны хувьд 4.5 их наяд төгрөг (2014 онд 4.5 ихнаяд төгрөг)-өөр хязгаарлагдана. Банк ашигласан хөрөнгийг буцаан төлөх өдрөө хүүг гэрээнд тусгайлан заасан хүүгийн түвшнээр тооцож төлөх үүрэгтэй. Банк юань ашигласан тохиолдолд хүүгийн түвшин нь 200 суурь нэгж дээр Шанхай-Интер Банк санал болгосон түвшинг (“ШИБОР”) нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин ХАБ төгрөг ашигласан тохиолдолд хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байх ба үүнийг мөн ашигласан хугацаанд тооцно.

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ашигласан дүнгийн үлдэгдэл 11.5 тэрбум юань буюу 3,536,710 сая төгрөг (2014 онд 9 тэрбум юань буюу 2,732,130 сая төгрөг) болж өссөн байна. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх ашиглаагүй дүн болох 3.5 тэрбум юаньтай тэнцэх 1,076,390 сая төгрөг нь (2014 онд 6 тэрбум юань буюу 1,821,420 сая төгрөг) ХАБ-ны зээлтэй холбоотой үүргийг илэрхийлнэ. 2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ашиглаагүй дүн болох 4.5 их наяд төгрөг нь Банкны зээлтэй холбоотой үүргийг илэрхийлнэ.

Бусад шийдэгдээгүй хэргүүд

Тодруулга 29-д дурдсан аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сангаас гадна, удирдлага нь 2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь хариуцагч талаар татагдсан, материаллаг алдагдалд хүргэж болох шийдэгдээгүй хэрэг байхгүй хэмээн дүгнэж байна. Тиймээс Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудад дээр дурдсан аккредитивтай холбоотой сангаас гадна сан байгуулах шаардлагагүй гэдэгт итгэж байна.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг тиймээс ч эдгээр эрсдэлийг тогтмол хянаж зөв зохистой бодлого баримтлах нь Банкны гол зорилго юм. Эдгээр эрсдэлийг зохистой удирдах нь Монголын банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж инфляцийг зохистой түвшинд барих зөв мөнгөний бодлого явуулахад чухал шаардлагатай. Эдгээр эрсдэлүүд нь Банкны тэргүүний зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Энэ нь Төв банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын ханшийн зөрүүнээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Эдгээр санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкинд тулгарах эрсдэлүүд нь санхүүгийн (зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн), үйл ажиллагааны, нэр хүндээ хадгалах мөн эрх зүйн эрсдэлүүдээс бүрдэнэ. Одоогоор Банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус бөгөөд газар тус бүрдээ тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлого баримталдаг. Банк нь Монгол улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах болон эрсдэлийн удирдлага, хяналттай холбоотой шийдвэрүүд гаргах эрх бүхий “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй хайж байна. Одоогоор “Хөрөнгө оруулалтын хороо” нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн удирдлагын алба болон Валют, эдийн засгийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн удирдлагын бүтэц

Захирлуудын зөвлөл нь эрсдэлүүдийг тодорхойлж хянахад эцсийн хариуцлага хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг удирдах, хянах үүрэг бүхий доорх бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын зөвлөл. Захирлуудын зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

Захирлуудын зөвлөл нь тайлант оны “Хөрөнгө оруулалтын бодлого”-ыг баталж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн Улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид танилцуулна. Үүнд гадаад валютын нөөцийн валютын бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэглүүр, харилцагч байгууллагууд болон тэдгээрт тавьсан хязгаарлалт зэргийг тусгана. Ерөнхийлөгч харилцагч байгууллагууд болон гаргагчийн зээлийн хязгаарыг улирал тутамд батлах бөгөөд энэ нь зээлийн эрсдэлийг удирдах гол арга юм.

Хяналтын зөвлөл. Хяналтын зөвлөл нь банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банкны эрсдэлийг ерөнхийд нь хянах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь Банкны эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн гол хэсэг бөгөөд Захирлуудын зөвлөл, Ерөнхийлөгчид эрсдэлийн удирдлагын бодлого дээр зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Валют эдийн засгийн газрын захирал, Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал, Эрсдэлийн удирдлагын албаны захирлууд багтдаг.

Банкны гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал ба энэ нь Банкны нийт хөрөнгөд гадаад валютын хөрөнгийн эзлэх хувиас хамаардаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын явуулдаг үйл ажиллагаа нь гадаад валютын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдан хяналт тавихад түлхүү чиглэгдэнэ.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрсдэлийн удирдлагын бүтэц (Үргэлжлэл)

Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба болон бусад холбогдох газруудад хяналт тавих бөгөөд тэдгээр нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэл болон хэрэгжилт бодлоготой нийцтэй байгаа эсэхэд анхаарч ажилладаг. Санхүүгийн эрсдэлийг удирдахад ашигласан аргуудыг доор дурьдав.

Эрсдэлийн удирдлагын алба. Эрсдэлийн удирдлагын алба ("ЭУА") нь гадаад валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаа, хараат бус хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого, хязгааруудын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг хариуцдаг.

Улсын гадаад валютын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын зорилго нь Банкны мөнгөний болон гадаад валютын бодлогод тусгагдсан байдаг. Гадаад валютын нөөцийн гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Зах зээлийн валютын ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын валютын өр төлбөрт баталгаа гаргах;
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэх.

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянаснаар гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлага нь эдгээр зорилгуудад хүрэхэд дэмжлэг болдог. Банк гадаад эрсдэлийг хянахын тулд хөрөнгийг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд хөрвөх валютын бэлэн байдлыг хадгалж байхад шаардлагатай валютын багцын бүтэц, хөрвөх чадвар ба аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангасан хөрөнгө оруулалтын хэрэглүүрүүдийн зөвшөөрөгдөх хязгаар, хүүгийн түвшний эрсдэлийг хязгаарлахад тавигдах хугацааны шаардлагууд зэрэгт зориулсан параметруудыг бий болгох ажил ордог.

Валют, эдийн засгийн газар

Валют, эдийн засгийн газар нь дамжуулан хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Валют, эдийн засгийн газрын захирал нь хөрөнгийн бүрдэл, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын хөрөнгийн хэмжээ зэрэг хөрөнгийн асуудлуудыг удирдан хянах үүрэгтэй.

Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар

Банк зорилгодоо хүрэх, бодлого төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд өөрийн үйл ажиллагаан дахь эрсдэлийн удирдлагын систем нь зохистой, үр ашигтай эсэхийг шалгах, үнэлэх нь Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (ДХҮАЭГ)-ын эрхэм зорилго юм. Банкны мөрдөж буй бодлого, горимуудын төлөвлөлт, зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилтийн хяналтын түвшний эрсдэлийн удирдлага, үйл ажиллагаа болон системүүд нь хууль журамд нийцэж буй эсэхийг шалгах түвшний эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн аюулгүй байдлыг шалгах түвшний эрсдэлийн удирдлага зэргийн зохистой, үр нөлөөтэй байдлыг шалгах, үнэлэх нь ДХҮАЭГ-ын үндсэн чиг үүрэг юм.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрсдэлийн удирдлагын бүтэц (Үргэлжлэл)

ДХҮАЭГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан хяналтын хүн хүч нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулах үед эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн үед хийдэг. Банкны ДХҮАЭГ нь 2015 оны хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэх замаар хяналтын ажлын дарааллыг тодорхойлдог. Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнэсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жигнэсэн онооны нийт дүнг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод хяналтын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагаануудын хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДХҮАЭГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДХҮАЭГ Банкны удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, гуравдагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болно. Банкны нэг төрлийн эрсдэл юм. Санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор гуравдагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон Банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог. Зээлийн эрсдэлийг удирдахдаа хөрөнгө оруулалт хийх хөрөнгөө зөв сонгох, нэг төрлийн хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаар тогтоох арга замаар удирддаг. Хөрөнгө оруулалтын төрөл, гуравдагч талуудаас хамааралтай үүдэх зээлийн эрсдэлийн түвшний хязгаарыг Удирдлагаас ойр ойрхон тогтоож жил тутам тогтмол хяналт тавьдаг.

Банк нь санхүүгийн хөрөнгийн зээлжих чанарыг олон улсын үнэлгээний байгууллагаас тогтоосон жишигт тулгуурладаг бол тухайн гадны байгууллагад (жишээлбэл Төв банк) тусгайлан тогтоосон үнэлгээ байхгүй тохиолдолд тухайн орны үнэлгээнд тулгуурлана. Банк нь хэрвээ олон улсын зах зээлийн байдал тогтворгүй байвал системийн эрсдэлд орохоос зайлсхийж тухайн байгууллагуудын үнэлгээг үл харгалзан үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатай.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг “AAA”-аас “AA-” үнэлгээтэй Засгийн газар (эсвэл Төв банк), “AAA” үнэлгээтэй олон улсын байгууллагууд болон агентлагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас “A-” болон түүнээс дээш үнэлгээ авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкны дахин санхүүжилтын журамд зааснаар Монголын дотоодын банкуудад санхүүгийн хэрэглүүрүүд олгоход ашигладаг барьцаа хөрөнгүүдийн үндсэн төрлүүдийг дор дурьдав:

1. Төв банкны үнэт цаас;
2. Засгийн газрын үнэт цаас;
3. Банкны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн байгууллагуудын өрийн бичиг;
4. Санхүүгийн байгууллагуудын гаргасан зээл.

Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах ёстой. Хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг л биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагаагаа цуцалдаг. Банк болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор барьцаа хөрөнгийн үнэлгээнд эрсдэлийн хямдруулалт хийдэг.

Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Үнэлэгдээгүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй болон бусад олдоцтой мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг.

Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ ашиглаагүй байна.

Гадаад валютын нөөцийн хувьд, бүх харилцагчдад зээлийн хязгаар байдаг бөгөөд тэдний үнэлгээ, санхүүгийн мэдээлэл болон бусад хүчин зүйлсийг харгалзан үздэг. Банкны Ерөнхийлөгч зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг Эрсдэлийн удирдлагын алба өдөр тутам хянана.

Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгийн насжилтын шинжилгээг хийдэг байна. Зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээллийг Захирлуудын зөвлөлд танилцуулах ба тэд үүнийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргана.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь санхүүгийн хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийг Мүүдигийн үнэлгээний системд үндэслэн үнэлж хөрөнгийн ангилал бүрээр харуулав. Доор харуулсан дүнгүүд нь үнэ цэнийн бууралтын алдагдлын санг оруулаагүй дүнгээр үзүүлэгдэж байна.

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтгүй					Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай	Нийт
	AAA сая төгрөг	AA сая төгрөг	A сая төгрөг	B сая төгрөг	Үнэлэг- дээгүй сая төгрөг	сая төгрөг	
Хөрөнгө							
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	19,551	350,415	595,693	–	416	–	966,075
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	522,587	–	–	105,945	1,819,315	–	2,447,847
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	827,134	–	–	370,327	130,560	–	1,328,021
Засгийн газрын үнэт цаас	–	–	–	202,218	–	–	202,218
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	602	–	–	8,372	–	–	8,974
Дотоодын банкуудад олгосон зээл	–	–	–	906,465	279,055	–	1,185,520
Бусад санхүүгийн хөрөнгө	–	–	–	4,500	472,382	222,757	699,639
	<u>1,369,874</u>	<u>350,415</u>	<u>595,693</u>	<u>1,597,827</u>	<u>2,701,728</u>	<u>222,757</u>	<u>6,838,294</u>

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтгүй				Үнэлэг-дээгүй сая төгрөг	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай сая төгрөг	Нийт сая төгрөг
	AAA сая төгрөг	AA сая төгрөг	A сая төгрөг	B сая төгрөг			
Хөрөнгө							
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	2,044	454,917	835,110	–	4	–	1,292,075
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	116,905	375,671	–	–	748,743	–	1,241,319
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	–	944,686	–	376,099	145,772	–	1,466,557
Засгийн газрын үнэт цаас	–	–	–	204,828	–	–	204,828
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	–	–	–	3,264	–	–	3,264
Дотоодын банкуудад олгосон зээл	–	–	–	1,668,890	417,055	73,812	2,159,757
Бусад санхүүгийн хөрөнгө	–	–	–	176,681	480,901	151,626	809,208
	<u>118,949</u>	<u>1,775,274</u>	<u>835,110</u>	<u>2,429,762</u>	<u>1,792,475</u>	<u>225,438</u>	<u>7,177,008</u>

Хэрэв үнэлэгдээгүй харилцагч тал нь улсын төв банк эсвэл гадаадын санхүүгийн байгууллага (жишээ нь Английн Төв банк) бол тэдгээрийн үнэлгээг тухайн улсын зээлийн зэрэглэлтэй тэнцүүгээр авсан. Бэлэн мөнгө болон ОУВС дахь зээлжих тусгай эрхийн хадгаламж нь Банкны хувьд зээлийн эрсдэлгүй юм.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Тодруулга 32-д толилуулснаар Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол улсын Засгийн газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа, үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно. Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын ардын банкттай хийсэн гэрээтэй холбоотой ба ашиглаагүй хэмжээгээр эрсдэл тодорхойлогдоно. Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 20, 21-д үзүүлсний дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон зээлийн хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 32-г харна уу).

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь хүүгийн түвшин болон валютын ханш гэх мэт зах зээлийн хувьсагчуудын өөрчлөлтөөс үүдэн хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэхдээ удирдлагын гол анхаардаг зүйл нь интервенцийн шаардлага, гадаадын өр төлбөр болон импортын бүтэц юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмжийн шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

Гадаад валютын эрсдэл

Валютын эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ нь валютын ханшны хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах хэмжүүрээр тодорхойлогдоно:

- Гадаад валютын нөөцийн удирдлагад ашигладаг валютууд;
- Гадаад валютын нөөцийн удирдлах зорилгоор гадаад валютаар илэрхийлэгдсэн активын тухайн валютын эзлэх хамгийн их хувь хэмжээ, богино ба урт хугацааны хөрөнгө оруулалтын багцыг тодорхойлно.

Гадаад нөөцийн валютын бүтцийг Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж жил бүр баталдаг.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Доорх хүснэгт нь 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц өртөж буй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг валют болон ЗТЭ-ээр илэрхийлэн харуулж байна.

	Санхүүгийн хөрөнгө сая төгрөг	Санхүүгийн өр төлбөр сая төгрөг	Дериватив сая төгрөг	Цэвэр позиц сая төгрөг
2015				
Ам.доллар	1,753,248	(998,563)	2,383,126	3,137,811
Монгол төгрөг	3,517,731	(2,629,640)	(2,891,984)	(2,003,893)
Юань	716,447	(4,173,295)	92,840	(3,364,008)
Евро	159,593	(141,148)	–	18,445
ЗТЭ	118,988	(143,264)	–	(24,276)
Бусад	524,377	(117,342)	–	407,035
	<u>6,790,384</u>	<u>(8,203,252)</u>	<u>(416,018)</u>	<u>(1,828,886)</u>
	Санхүүгийн хөрөнгө сая төгрөг	Санхүүгийн өр төлбөр сая төгрөг	Дериватив сая төгрөг	Цэвэр позиц сая төгрөг
2014				
Ам.доллар	1,728,835	(1,446,273)	(1,578,416)	(1,295,854)
Монгол төгрөг	4,149,828	(3,539,774)	1,310,045	1,920,099
Юань	160,628	(2,786,257)	181,925	(2,443,704)
Евро	240,376	(177,788)	–	62,588
ЗТЭ	117,276	(141,472)	–	(24,196)
Бусад	732,282	(189,076)	–	543,206
	<u>7,129,225</u>	<u>(8,280,640)</u>	<u>(86,446)</u>	<u>(1,237,861)</u>

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцэст гадаад валютын болон ЗТЭ-ын ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтөд ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгийн үзүүлэх мэдрэмжийг харуулсан. Хүснэгт дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг, алдагдал дахь болзошгүй цэвэр хасагдуулгыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валют	Валютын ханшийн өөрчлөлт хувиар	Орлогын тайлан ба өмчийн хөрөнгө дахь нөлөө	Валютын ханшийн өөрчлөлт хувиар	Орлого, зардлын данс ба өмчийн хөрөнгө дэх нөлөө
	2015	2015 сая төгрөг	2014	2014 сая төгрөг
Ам.доллар	15% (15%)	470,672 (470,672)	15% (15%)	(194,378) 194,378
Юань	15% (15%)	(504,601) 504,601	15% (15%)	(366,556) 366,556
Евро	15% (15%)	2,766 (2,766)	15% (15%)	9,388 (9,388)
ЗТЭ	15% (15%)	(3,641) 3,641	15% (15%)	(3,629) 3,629
Бусад	15% (15%)	(103) 103	15% (15%)	81,481 (81,481)

Эрсдэлийн нөлөөний хэмжээ нь Банкны үндсэн үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг) болон ЗТЭ-д хамаарагдах мөнгөн нэгжээс бусад валютын хувьд тооцоологдсон болно.

Хүүгийн түвшний эрсдэл

Тус эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс үүдэн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэд нөлөөлж болох эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол зорилго нь хөрөнгө оруулалт тус бүрээс эрсдэлийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

Банкны хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг ихээхэн хэмжээгээр бууруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцдаа, хүүгийн түвшингийн эрсдэлийг багасгах зорилгоор Банк гадаад валютын нөөцийн багцдаа хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөнгийн шинжилгээний (investment horizon) аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр, сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5%-аас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн байдлыг харуулав. Энэ хүснэгтэд Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн түвшин өөрчлөгдсөн буюу зээлийн хугацаа дуусгавар болсон өдрүүдийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна.

	Нийт	Хугацаагүй болон 1 сараас бага	1 – 6 сарын хооронд	6 – 12 сарын хооронд	12 сараас дээш	Хүү тооцдоггүй
	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
2015						
Нийт санхүүгийн хөрөнгө	7,219,667	1,787,315	142,296	1,160,687	2,615,698	1,513,671
Нийт санхүүгийн өр төлбөр	(8,625,149)	(2,422,563)	(3,794,485)	(61,662)	(26,782)	(2,319,657)
Нийт хүүгийн мэдрэмжийн зөрүү	(1,405,482)	(635,248)	(3,652,189)	1,099,025	2,588,916	(805,986)
2014						
Нийт санхүүгийн хөрөнгө	7,466,414	3,209,462	1,716,692	652,480	971,862	915,918
Нийт санхүүгийн өр төлбөр	(8,370,350)	(5,265,045)	(2,855,319)	(833)	(29,080)	(220,073)
Нийт хүүгийн мэдрэмжийн зөрүү	(903,936)	(2,055,583)	(1,138,627)	651,647	942,782	695,845

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хувьд хөвөгч хүүгээр хуримтлагдсан хүү бодогддог: Үүнд ЗТЭ (Тодруулга 14), ЗТЭ-ийн хуваарилалт, Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан юанийн санхүүжилт болон Токио Мицүбиши Юү Эф Жи Сингапур банкнаас авсан алтны урьдчилгаа санхүүжилтүүд (Тодруулга 28) орно. Дараах хүснэгтэд Банкны орлого, зардлын дансны зүйлсийн бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүгийн хувь хэмжээний үндэслэлтэй, боломжит өөрчлөлтөд үзүүлэх мэдрэмжийг харуулав.

	Орлого, зардлын данс болон өмчид үзүүлэх нөлөө сая төгрөг
2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	
100 үндсэн нэгжийн өсөлт	(37,924)
100 үндсэн нэгжийн бууралт	37,924
2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	
100 үндсэн нэгжийн өсөлт	(28,386)
100 үндсэн нэгжийн бууралт	28,386

Дээрх орлого, зардлын данс дахь нөлөөний гол шалтгаан нь хүүгийн хувь өсч (багассан) тохиолдолд хүүгийн өр төлбөрт, ялангуяа Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан юанийн санхүүжилт болон Токио Мицүбиши Юү Эф Жи Сингапур банкнаас авсан алтны урьдчилгаа санхүүжилтэд төлсөн хүүгийн зардал (их) бага болохтой холбоотой.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бүс нутгийн төвлөрлийн эрсдэл. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны хөрөнгө болон өр төлбөрийг газарзүйн байршлаар нь дор харуулав.

	Монгол сая төгрөг	ЭЗХАХБ сая төгрөг	ОУВС сая төгрөг	ЭЗХАХБ бүс сая төгрөг	Нийт сая төгрөг
2015					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	53,793	–	–	–	53,793
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	–	845,580	118,988	120,495	1,085,063
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	1,930,376	522,588	–	6,080	2,459,044
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	500,887	827,134	–	–	1,328,021
Алт ба үнэт метал	264,108	156,044	–	–	420,152
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	8,372	602	–	–	8,974
Засгийн газрын үнэт цаас	202,218	–	–	–	202,218
Дотоодын банкуудад олгосон зээл	1,185,520	–	–	–	1,185,520
Бусад санхүүгийн хөрөнгө	453,388	23,494	–	–	476,882
Нийт санхүүгийн хөрөнгө	4,598,662	2,375,442	118,988	126,575	7,219,667
Хөрөнгийн үүрэг	–	–	–	1,076,390	1,076,390
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	706,656	–	–	–	706,656
Төв банкны үнэт цаас	1,024,581	–	–	–	1,024,581
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	702,456	–	–	–	702,456
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,818,985	–	–	–	1,818,985
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	424,995	–	–	–	424,995
Гадаад өр төлбөр	–	–	135,180	3,790,597	3,925,777
Бусад санхүүгийн өр төлбөр	21,699	–	–	–	21,699
Нийт санхүүгийн өр төлбөр	4,699,372	–	135,180	3,790,597	8,625,149
Цэвэр дүн	(100,710)	2,375,442	(16,192)	(3,664,022)	(1,405,482)
Болзошгүй өр төлбөр ба үүрэг	(12)	(411,390)	–	(4,500,000)	(4,911,402)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бүс нутгийн төвлөрлийн эрсдэл. 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны хөрөнгө болон өр төлбөрийг газарзүйн байршлаар нь дор харуулав.

	Монгол сая төгрөг	ЭЗХАХБ сая төгрөг	ОУВС сая төгрөг	ЭЗХАХБ бүс сая төгрөг	Нийт сая төгрөг
2014					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	57,990	–	–	–	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	–	1,128,547	117,276	163,527	1,409,350
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	749,233	492,576	–	5,130	1,246,939
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	521,871	944,686	–	–	1,466,557
Алт ба үнэт метал	125,456	208,503	–	–	333,959
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	2,720	–	–	544	3,264
Засгийн газрын үнэт цаас	204,828	–	–	–	204,828
Дотоодын банкуудад олгосон зээл	2,085,945	–	–	–	2,085,945
Бусад санхүүгийн хөрөнгө	635,387	22,195	–	–	657,582
Нийт санхүүгийн хөрөнгө	4,383,430	2,796,507	117,276	169,201	7,466,414
Хөрөнгийн үүрэг	–	–	–	1,821,420	1,821,420
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	809,657	–	–	–	809,657
Төв банкны үнэт цаас	853,781	–	–	–	853,781
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	798,649	–	–	–	798,649
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	2,803,462	–	–	–	2,803,462
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	89,710	–	–	–	89,710
Гадаад өр төлбөр	–	–	133,262	2,854,626	2,987,888
Бусад санхүүгийн өр төлбөр	27,204	–	–	–	27,204
Нийт санхүүгийн өр төлбөр	5,382,463	–	133,262	2,854,626	8,370,351
Цэвэр дүн	(999,033)	2,796,507	(15,986)	(2,685,425)	(903,937)
Болзошгүй өр төлбөр ба үүрэг	(31,867)	(106,354)	–	(4,500,000)	(4,638,221)

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад эрсдэлийн төвлөрөл

Банкны Удирдлага дээр дурдсан харилцагчдын хязгаар бүрт зээлдэгчдийн талаарх тайлан мэдээллийг авах замаар зээлийн эрсдэлийн төвлөрлийг судалж, хяналт тавьдаг. 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд ийм төрлийн томоохон эрсдэлийн төвлөрөл байхгүй байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүнд нөхцөл байдалд өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Гадаад валютын хөрвөх чадварын эрсдэл нь Банкинд учирдаг хамгийн гол эрсдэлүүдийн нэг юм. Импортоос ихээхэн хамааралтай, Засгийн газрын гадаад өрийг байнга төлж байх шаардлагатай, дотоодын зах зээл дээрх валютын эрэлт, нийлүүлэлт байнга хэлбэлзэж байдаг нөхцөл байдлын үед төлбөрийн чадвар нь гадаад валютын нөөцийн удирдлагын авч үзэх ёстой чухал асуудал юм. Төлбөрийн чадварыг удирдахын тулд Банк гадаад валютын нөөцийн багцыг хоёр дэд багцад хуваадаг. Үүнд:

- Төлбөрийн чадварын багц (бэлэн мөнгөний удирдлага эсвэл төлбөрийн чадварын багц орно): Энэ багц нь зээлийн өр төлөх, валютын зах зээлийн үйл ажиллагааг тогтвортой болгох зорилгоор ашигладаг. Энд бэлэн мөнгө, овернайт ба хугацаагүй хадгаламжаас бүрдэнэ. Энэхүү багц нь мөн хугацаат хадгаламжид, өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий мөнгөний зах зээлийн хэрэглүүрт долоо хоногоос 12 сар хүртэлх дуусах хугацаа бүхий үнэт цаасанд болон мөнгөжсөн алтанд хөрөнгө оруулалт болон хийгддэг байна.
- Хөрөнгө оруулалтын багц: Энэ багц нь дунд хугацааны, өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий АНУ-ын Засгийн газар, хэд хэдэн улсын болон агентлагуудын гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг байна.

Захирлуудын зөвлөл стратегийн зорилт, гадаад валютын нөөцийн багцын хугацааг баталдаг. Эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг бууруулахын тулд Улсын гадаад валютын нөөцийн удирдлагын журмын дагуу дараах хөрөнгийн бүтцийг тогтоосон:

- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийн богино хугацаат (1 жил хүртлэх) хөрөнгө болгон харилцах данс болон валютаар илэрхийлэгдсэн бэлэн мөнгө хэлбэрээр байршуулах;
- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийн богино хугацаат (1 жил хүртлэх) хөрөнгө болгон 6 сар хүртэлх хугацаатай хадгаламжийн хэлбэрээр байршуулах.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн өр төлбөрийг гэрээнд заасан дуусах хугацаагаар нь харуулсан. Дуусгавар хугацааны тайланд тусгасан өглөгүүд нь нийт зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааг оруулан гэрээнд заасан хямдруулаагүй мөнгөн гүйлгээ болно. Санхүүгийн байдлын тайланд дүнгүүд нь хямдруулсан мөнгөн гүйлгээн дээр үндэслэсэн байх тул хямдруулаагүй мөнгөн гүйлгээ нь тайланд тусгасан дүнгээс зөрүүтэй байна. Санхүүгийн хэрэглүүрүүд нь форвард болон своп хэлцлүүдээс хүлээн авах болон төлөгдөх гэрээний дүнд орсон болно.

Аккредитивийг дэмжихэд шаардагдах төлбөрийн чадварын хэмжээ нь дуусах хугацааны шинжилгээнд харуулсан өр төлбөрийн хариуцлагын хэмжээнээс бага юм. Учир нь Банк гуравдагч талыг эдгээр гэрээн дээр үндэслэн хөрөнгө татна гэж үздэггүй байна. Доорх дуусгавар хугацааны шинжилгээний хүснэгт дэх одоогийн нийт гэрээнд үндэслэсэн өр төлбөрийн хэмжээ нь ирээдүйд шаардлагатай мөнгөний хэмжээг илэрхийлэхгүй. Учир нь ихэнх энэ төрлийн гэрээт өр төлбөр нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

Өр төлбөрийн дүн тодорхой бус тохиолдолд тодруулсан дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлын үндсэн дээр тодорхойлно. Гадаад валютаар хийсэн төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшаар шилжүүлэн тооцно.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Хямдруулаагүй мөнгөн урсгал дээр үндэслэсэн санхүүгийн өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав:

2015	Хугацаагүй ба 1 сараас бага сая төгрөг	1 – 6 сарын хооронд сая төгрөг	6 – 12 сарын хооронд сая төгрөг	12 сараас дээш сая төгрөг	Нийт сая төгрөг
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	706,656	–	–	–	706,656
Төв банкны үнэт цаас	1,026,800	–	–	–	1,026,800
Засгийн газрын байгууллагад төлөх өр төлбөр	671,207	1,194	1,242	39,304	712,947
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,758,355	–	63,105	–	1,821,460
Гадаад өр төлбөр	138,554	3,135,303	712,121	–	3,985,978
Бусад санхүүгийн өр төлбөр	21,699	–	–	–	21,699
Нийт төлөгдсөн своп болон форвард хэлцэлүүд:					
- Орох урсгал	(295,290)	(198,630)	(80,927)	(2,151,590)	(2,726,437)
- Гарах урсгал	298,120	195,887	82,744	2,565,707	3,142,458
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
- ХАБ-с авах ашиглаагүй зээлийн шугам	(1,076,390)	–	–	–	(1,076,390)
- ХАБ-д өгөх ашиглаагүй зээлийн шугам	4,500,000	–	–	–	4,500,000
- Бусад болзошгүй өр төлбөр	411,390	–	–	12	411,402
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	8,161,101	3,133,754	778,285	453,433	12,526,573

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Хямдруулаагүй мөнгөн урсгал дээр үндэслэсэн санхүүгийн өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав:

2014	Хугацаагүй ба 1 сараас бага сая төгрөг	1 – 6 сарын хооронд сая төгрөг	6 – 12 сарын хооронд сая төгрөг	12 сараас дээш сая төгрөг	Нийт сая төгрөг
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	809,657	–	–	–	809,657
Төв банкны үнэт цаас	855,650	–	–	–	855,650
Засгийн газрын байгууллагад төлөх өр төлбөр	767,874	862	833	29,080	798,649
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	2,803,462	–	–	–	2,803,462
Гадаад өр төлбөр	135,348	2,832,274	179,248	–	3,146,870
Бусад санхүүгийн өр төлбөр	27,204	–	–	–	27,204
Нийт төлөгдсөн своп болон форвард хэлцэлүүд:					
- Орох урсгал	(485,945)	(118,375)	(26,677)	(860,457)	(1,491,454)
- Гарах урсгал	506,130	117,040	27,324	927,406	1,577,900
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
- ХАБ-с авах ашиглаагүй зээлийн шугам	(1,821,420)	–	–	–	(1,821,420)
- ХАБ-д өгөх ашиглаагүй зээлийн шугам	4,500,000	–	–	–	4,500,000
- Бусад болзошгүй өр төлбөр	109,055	6,758	22,408	–	138,221
Санхүүгийнүүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	8,207,015	2,838,559	203,136	96,029	11,344,739

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Дотоодын банкнаас байршуулсан хадгаламж болон төрийн байгууллагуудад өгөх өр төлбөрүүдийн ихэнх хэсэг нь Банк үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэр болон үндсэн хадгаламжийг илэрхийлж байна. Үүнтэй адилаар Банк хэдийгээр гэрээний дагуу төлбөр хийх хугацааг хойшлуулах эрхгүй боловч гүйлгээнд байгаа бэлэн мөнгө мөн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг илэрхийлж байна.

Банк нь дуусах хугацааны хямдруулаагүй шинжилгээг хэрэглэдэггүй. Харин Банк санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бүртгэлийн дүнгийн хүлээгдэж буй дуусах хугацаа болон үүнээс үүдэх цэвэр позиц (төлбөрийн чадварын зааг)-ийг хянадаг. Доорх хүснэгт санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүлээгдэж буй дуусах хугацааны шинжилгээг харуулсан байна.

Санхүүгийн өр төлбөрийн хүлээгдэж буй дуусах хугацаа нь Банкинд байршуулсан их хэмжээний мөнгө (ихэвчлэн төрийн байгууллагууд болон дотоодын банкуудаас байршуулсан) болон гүйлгээн дэх бэлэн мөнгөнөөс шалтгаалаад гэрээнд заасан дуусах хугацаанаасаа өөр байж болно. Хэрэв санхүүгийн өр төлбөрийг төлөх шаардлага гарахад борлуулахад бэлэн байдаг санхүүгийн хөрөнгө нь борлуулагдахаар хүлээгдэж буй өдөртөө үндэслэн дуусах хугацааны шинжилгээнд хамрагдана. Үнэ цэнийн бууралтад орсон зээл нь ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалынхаа цаг хугацаанд тулгуурлан үнэ цэнийн бууралтын сангийн цэвэр дүнд хамаарагдана.

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар хугацааны шинжилгээг хүлээгдэж буй дуусгавар болох хугацаан дээр үндэслэн 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав:

	Хугацаагүй болон 1 сараас бага сая төгрөг	1 – 6 сарын хооронд сая төгрөг	6 – 12 сарын хооронд сая төгрөг	12 сараас дээш сая төгрөг	Нийт сая төгрөг
2015					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	53,793	–	–	–	53,793
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,084,137	–	–	926	1,085,063
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	266,230	95,492	73,856	2,023,466	2,459,044
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,328,021	–	–	–	1,328,021
Алт ба үнэт метал	420,152	–	–	–	420,152
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	623	4,660	941	2,750	8,974
Засгийн газрын үнэт цаас	–	2,432	103,218	96,568	202,218
Дотоодын банкуудад олгосон зээл	175,684	110,173	7,649	892,014	1,185,520
Бусад санхүүгийн хөрөнгө	4,553	2,475	11	469,843	476,882
Нийт санхүүгийн хөрөнгө	3,333,193	215,232	185,675	3,485,567	7,219,667
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	706,656	–	–	–	706,656
Төв банкны үнэт цаас	1,024,581	–	–	–	1,024,581
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	673,573	1,069	1,032	26,782	702,456
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,759,106	–	59,879	–	1,818,985
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	4,984	387	2,757	416,867	424,995
Гадаад өр төлбөр	132,361	3,553,862	239,554	–	3,925,777
Бусад өр төлбөр	1,023	168	–	20,508	21,699
Нийт өр төлбөр	4,302,284	3,555,486	303,222	464,157	8,625,149
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	(969,091)	(3,340,254)	(117,547)	3,021,410	(1,405,482)

33. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар хугацааны шинжилгээг хүлээгдэж буй дуусгавар болох хугацаан дээр үндэслэн 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

	Хугацаагүй болон 1 сараас бага сая төгрөг	1 – 6 сарын хооронд сая төгрөг	6 – 12 сарын хооронд сая төгрөг	12 сараас дээш сая төгрөг	Нийт сая төгрөг
2014					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	57,990	–	–	–	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,408,474	–	–	876	1,409,350
Борлуулахад бэлэн Санхүүгийн хөрөнгө оруулалт	245,636	80,693	28,325	892,285	1,246,939
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,466,557	–	–	–	1,466,557
Алт ба үнэт метал	333,959	–	–	–	333,959
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	541	1,335	–	1,388	3,264
Засгийн газрын үнэт цаас	–	2,424	–	202,404	204,828
Дотоодын банкуудад олгосон зээл	9,136	1,271,187	436,661	368,961	2,085,945
Бусад санхүүгийн хөрөнгө	87	187,595	–	469,900	657,582
Нийт санхүүгийн хөрөнгө	3,522,380	1,543,234	464,986	1,935,814	7,466,414
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	809,657	–	–	–	809,657
Төв банкны үнэт цаас	853,781	–	–	–	853,781
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	767,903	833	833	29,080	798,649
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	2,803,462	–	–	–	2,803,462
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	20,725	–	648	68,337	89,710
Гадаад өр төлбөр	133,403	2,831,785	22,700	–	2,987,888
Бусад өр төлбөр	9,133	62	–	18,009	27,204
Нийт өр төлбөр	5,398,064	2,832,680	24,181	115,426	8,370,351
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	(1,875,684)	(1,289,446)	440,805	1,820,388	(903,937)

34. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Доорх хүснэгт нь Банкинд ашиглагдаж байгаа өглөг болон авлагын хувьд гадаад валютын ханшийн хөрвүүлэгт ашиглагдах своп болон форвард хэлцэлээр тайлангийн эцэст бодит үнэ цэнийг тусган харуулж байна. Доорх хүснэгт нь тухайн тайлант хугацаанаас хойш төлбөр төлөгдөх гэрээтэй, харилцагч талуудын төлбөрийг барагдуулахаас өмнөх нийт позицыг үзүүлэв.

	Хөрөнгө 2015 сая төгрөг	Өр төлбөр 2015 сая төгрөг	Хөрөнгө 2014 сая төгрөг	Өр төлбөр 2014 сая төгрөг
Гадаад валютын ханшийн хөрвүүлэлт своп, форвард: тайлангийн эцэс дэхь бодит үнэ цэнэ				
- Төлбөр хийгдэхэд авах ам. долларын авлага (+)	404,590	2,134,581	–	202,175
- Төлбөр хийгдэхэд төлөх ам. долларын өглөг (-)	(71,050)	(84,997)	(322,683)	(1,032,806)
- Төлбөр хийгдэхэд авах төгрөгийн авлага (+)	10,066	84,359	325,947	781,349
- Төлбөр хийгдэхэд төлөх төгрөгийн өглөг (-)	(421,301)	(2,565,109)	–	(222,353)
- Төлбөр хийгдэхэд авах юанийн авлага (+)	86,669	6,171	–	181,925
Своп, форвард хэлцэлийн валютын ханшийн цэвэр бодит үнэ цэнэ	8,974	(424,995)	3,264	(89,710)

Банк нь зах зээл дэх мэргэжлийн байгууллагуудтай стандарт гэрээ байгуулж гадаад валютын үүсмэл санхүүгийн хэрэгслээр зуучлагч оролцуулалгүй зах зээлд арилжаа хийдэг. Дериватив нь нөхцөлөөсөө хамаараад зах зээлийн хүүгийн түвшин, гадаад валютын ханш болон бусад хувьсагчийн өөрчлөлтийн үр дүнд эерэг (хөрөнгө) эсвэл сөрөг (өр төлбөр) нөлөөтэй байж болно. Нийт дериватив санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ цаг хугацааны үр дүнд үлэмж хэмжээгээр өөрчлөгдөж болно.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Бодит үнэ цэнэ гэдэг нь дампуурсан болон албадан борлуулахад хүрсэн этгээдээс бусад аливаа сонирхож буй талуудын хооронд санхүүгийн хэрэглүүрийн зах зээл дээр арилжаалагдах дүн юм. Зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрийн хувьд Банк үнэлгээний техникүүдийг ашигласан.

Банк нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

Түвшин 1: ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн хувьд идэвхитэй зах зээл дээр бүртгэгдсэн (залруулаагүй) үнэ;

Түвшин 2: бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, зах зээл дээр шууд болон шууд бусаар ажиглагддаг хүчин зүйлсийг ашигладаг үнэлгээний аргачлалууд;

Түвшин 3: бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашигладаггүй аргачлалууд.

Доорх хүснэгтэд Банкны хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтийн шатлалыг харуулав.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийн шатлалын тоон үзүүлэлтийг толилуулав:

	Нийт сая төгрөг	Бодит үнэ цэнийн хэмжилт		
		Идэвхитэй зах зээл дээр бүртгэгдсэн (Түвшин 1) сая төгрөг	Мэдэгдэ- хүйц ажиглагд- даг хүчин зүйлс (Түвшин 2) сая төгрөг	Мэдэгдэ- хүйц ажиглагд- даггүй хүчин зүйлс (Түвшин 3) сая төгрөг
2015				
Санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнээр				
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт				
РАМП хөрөнгө оруулалтын данс	201,187	201,187	—	—
ОУ-ын төлбөр тооцооны банкны бонд	119,726	119,726	—	—
АНУ-ын Засгийн газрын бонд	197,687	197,687	—	—
ОУСБХБ-ны Засгийн газрын агентлаг	3,988	3,988	—	—
Давуу эрхтэй ИЗББ	1,819,314	—	—	1,819,314
МИК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт	5,055	5,055	—	—
Хөгжлийн банкны үнэт цаас	105,945	—	105,945	—
Алт, үнэт метал				
Мөнгөжсөн алт	153,097	153,097	—	—
Мөнгөжсөн мөнгө	343	343	—	—
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	8,974	—	8,974	—
Дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө				
Барилга/байгууламж	22,305	—	—	22,305
Санхүүгийн өр төлбөр, бодит үнэ цэнээр				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	424,995	—	424,995	—

МИК 2015 оны 12 дугаар сарын 24-нд Монголын хөрөнгийн биржид Хувьцаат компаниар бүртгэгдсэнтэй холбогдуулан МИК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт Түвшин 2-оос Түвшин 1-рүү шилжсэн ба бодит үнэ цэнийн шатлалын хооронд үүнээс өөр хөдөлгөөн тайлант жилд гараагүй болно.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

		Бодит үнэ цэнийн хэмжилт		
		Идэвхитэй зах зээл дээр бүртгэгдсэн (Түвшин 1) сая төгрөг	Мэдэгдэ- хүйц ажиглагд- даг хүчин зүйлс (Түвшин 2) сая төгрөг	Мэдэгдэ- хүйц ажиглагд- даггүй хүчин зүйлс (Түвшин 3) сая төгрөг
2014	Нийт сая төгрөг			
Санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнээр				
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт				
РАМП хөрөнгө оруулалтын данс	189,681	189,681	—	—
ОУ-ын төлбөр тооцооны банкны бонд	113,133	113,133	—	—
АНУ-ын Засгийн газрын бонд	185,990	185,990	—	—
ОУСБХБ-ы Засгийн газрын агентлаг	3,770	3,770	—	—
Давуу эрхтэй ИЗББ	748,742	—	—	748,742
Алт, үнэт метал				
Мөнгөжсөн алт	207,066	207,066	—	—
Мөнгөжсөн мөнгө	116	116	—	—
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	3,264	—	3,264	—
Дахин үнэлэгдсэн барилга	22,305	—	—	22,305
Санхүүгийн өр төлбөр, бодит үнэ цэнээр				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	89,710	—	69,533	20,177

Доорх хүснэгтэд ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан дахь бодит үнэ цэнээр хэмжсэн 3 дугаар түвшний хөрөнгө болон өр төлбөрийн ашиг, алдагдлыг харуулж байна.

3 дугаар түвшний хөрөнгө ба өр төлбөр	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Орлогын тайланд бүртгэгдсэн бодит бус алдагдал		
-Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	—	(20,177)
	—	(20,177)

Түвшин 2 ба Түвшин 3-ийн хооронд тайлант жилд ямар нэгэн хөдөлгөөн гараагүй.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр- Дериватив

Зах зээлийн ажиглагдахуйц хүчин зүйлийн үнэлгээний аргачлал ашиглан хэмжсэн дериватив санхүүгийн бүтээгдэхүүнүүд нь голдуу валютын своп, гадаад валютын форвард арилжааны хэлцлүүд байна. Хамгийн их ашигладаг үнэлгээний аргачлал нь өнөөгийн үнэ цэнийг ашиглан тооцолсон форвард болон своп үнэлгээний загварууд байдаг. Уг загвар нь гадаад валютын төрөл бүрийн өгөгдлийг (своп болон форвард ханшийг оролцуулан) ашигладаг.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Барилга байгууламжийн бодит үнэ цэнийг өртгийн аргаар тодорхойлсон ба үнэлгээчин Монгол улсын Засгийн газрын 336 дугаар тогтоолоор батлагдсан барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээнд суурилж үнэлгээгээ хийсэн. Үнэлгээний өдөр буюу 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хөрөнгийн бодит үнэ цэнэ нь албан ёсны эрхтэй, хараат бус үнэлгээний компаниудийн консорциумын үнэлгээгээр үнэлэгдсэн байна.

Мэдэгдэхүйц ажиглагддаггүй үнэлгээний хүчин зүйл:
Оффисын барилгын метр.квадратын үнэ: 619.27 мянган төгрөг
Банкны барилгын метр.квадратын үнэ: 593.34 мянган төгрөг
Гражийн метр.квадратын үнэ: 509.80 мянган төгрөг

Барилга бүрийн метр.квадратын тооцолсон үнийн томоохон өсөлт (бууралт) нь бодит үнэ цэнийг ихээхэн хэмжээгээр өсгөнө (бууруулна).

Үнэлгээний мэдэгдэхүйц ажиглагддаггүй дээрх өгөгдлүүд нь 2013 онд Банкны хийсэн үнэлгээнд суурилсан. Банк эдгээр өгөгдлүүд нь 2015 онд томоохон хэмжээгээр өөрчлөгдөөгүй гэж үнэлсэн.

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй Банкны санхүүгийн хэрэгслүүдийг ангилал бүрээр нь дансны болон бодит үнэ цэнээр нь харьцуулан дараах хүснэгтээр харууллаа. Энэхүү хүснэгтэд санхүүгийн бус хөрөнгө болон санхүүгийн бус өр төлбөрийн бодит үнэ цэнийг оруулаагүй болно.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ (Үргэлжлэл)

	2015		2014	
	Дансны үнэ сая төгрөг	Бодит үнэ сая төгрөг	Дансны үнэ сая төгрөг	Бодит үнэ сая төгрөг
Санхүүгийн хөрөнгө				
Бэлэн мөнгө	53,793	53,793	57,990	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,085,063	1,085,063	1,409,350	1,409,350
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,328,021	1,328,021	1,466,557	1,466,557
Засгийн газрын үнэт цаас	202,218	202,218	204,828	204,828
Дотоодын банкуудад олгосон зээл	1,185,520	1,185,434	2,085,945	2,085,216
Бусад санхүүгийн хөрөнгө	476,882	476,870	657,582	657,571
	4,331,497	4,331,399	5,882,252	5,881,512
Санхүүгийн өр төлбөр				
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	706,656	706,656	809,657	809,657
Төв банкны үнэт цаас	1,024,581	1,023,668	853,781	853,781
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	702,456	702,404	798,649	798,620
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,818,985	1,818,985	2,803,462	2,803,462
Гадаад өр төлбөр	3,925,777	3,911,685	2,987,888	2,956,041
Бусад санхүүгийн өр төлбөр	21,699	21,699	27,204	27,142
	8,200,154	8,185,097	8,280,641	8,248,703

Бодит үнэ цэнэ нь бодит үнэ цэнийн хүснэгтэд багтсан боловч бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Эдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажиглахуйц өгөгдөхүүн ашигласан үнэлгээний аргачлалаар (тодорхойлбол хямдруулсан мөнгөн гүйлгээний загвар) тодорхойлноор түвшин 2-т ангилагдсан.

36. ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Доорх хүснэгтэд тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор болон 12 сарын дараа төлөгдөхөөр хүлээгдэж буй дүнгүүдийг санхүүгийн тайлангийн зүйл бүрээр харуулав.

2015 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар	12 сарын дотор сая төгрөг	12 сарын дараа сая төгрөг	Нийт сая төгрөг
Хөрөнгө			
Бэлэн мөнгө	53,793	–	53,793
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,084,137	926	1,085,063
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	435,578	2,023,466	2,459,044
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,328,021	–	1,328,021
Алт ба үнэт метал	414,410	5,742	420,152
Засгийн газрын үнэт цаас	105,650	96,568	202,218
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	6,312	2,662	8,974
Дотоодын банкуудад олгосон зээл	293,506	892,014	1,185,520
Бусад хөрөнгө	7,569	469,844	477,413
Борлуулахаар эзэмшиж буй хөрөнгө	4,665	–	4,665
Нийт хөрөнгө	3,733,641	3,491,222	7,224,863
Өр төлбөр			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	706,656	–	706,656
Төв банкны үнэт цаас	1,024,581	–	1,024,581
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	675,674	26,782	702,456
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,818,985	–	1,818,985
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	339,333	85,662	424,995
Гадаад өр төлбөр	3,925,777	–	3,925,777
Бусад өр төлбөр	17,158	61,487	78,645
Нийт өр төлбөр	8,508,164	112,444	8,682,095
Цэвэр дүн	(4,774,523)	3,317,291	(1,457,232)

36. ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2014 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар	12 сарын дотор сая төгрөг	12 сарын дараа сая төгрөг	Нийт сая төгрөг
Хөрөнгө			
Бэлэн мөнгө	57,990	–	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,408,474	876	1,409,350
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	354,654	892,285	1,246,939
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,466,557	–	1,466,557
Алт ба үнэт метал	329,656	4,303	333,959
Засгийн газрын үнэт цаас	2,424	202,404	204,828
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,876	1,388	3,264
Дотоодын банкуудад олгосон зээл	1,716,985	368,960	2,085,945
Бусад хөрөнгө	188,252	469,900	658,152
Борлуулахаар эзэмшиж буй хөрөнгө	450	–	450
Нийт хөрөнгө	5,527,318	1,940,116	7,467,434
Өр төлбөр			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	809,657	–	809,657
Төв банкны үнэт цаас	853,781	–	853,781
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	769,569	29,080	798,649
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	2,803,462	–	2,803,462
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	21,373	68,337	89,710
Гадаад өр төлбөр	2,987,888	–	2,987,888
Бусад өр төлбөр	17,711	63,760	81,471
Нийт өр төлбөр	8,263,441	161,177	8,424,618
Цэвэр	(2,736,123)	1,778,939	(957,184)

37. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Хэрэв хоёр этгээд нэг хяналтын дор байдаг эсвэл нэг тал нөгөө талыг хянах эрхтэй буюу нөгөө талд санхүүгийн ба үйл ажиллагааны шийдвэр гаргахад нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг талуудыг ерөнхийдөө холбоотой талууд гэж үздэг. Холбоотой тал тус бүрийн хамаарлыг авч үзэхдээ хуулийн хүрээнээс илүү холбоо хамаарлын шинж чанарыг нь авч үздэг.

Банк 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах холбоотой талуудтай хийсэн гүйлгээ болон дансдын үлдэгдлийг толилуулсан. Үүнд: Засгийн газар (Сангийн яам гэх мэт удирдлагыг нь Засгийн газраас томилдог байгууллагууд), удирдлагыг нь Засгийн газраас томилж, Сангийн яам болон ХДК эзэмшдэг Төрийн банк, удирдлагыг нь Засгийн газраас томилж, Сангийн яам эзэмшдэг Хөгжлийн банк, Банкны дэд ерөнхийлөгчийн даргалсан Үндэсний хорооны долоон гишүүд тус бүрийн саналаар үйл ажиллагааны бүх шийдвэрүүд нь батлагдаж, Засгийн газрын эзэмшдэг Хадгаламжийн даатгалын корпораци хамаарна.

НББОУС 24-т заасан “Засгийн газартай холбоотой байгууллагууд толилуулгын шаардлагаас хэсэгчлэн чөлөөлөгдөнө” гэсэн өөрчлөлтийг Банк хэрэглэсэн байна. Тиймээс Засгийн газартай холбоотой байгууллагуудтай хийсэн дангаараа материаллаг бус ажил гүйлгээнүүдийг энэхүү санхүүгийн тайлангуудад толилуулаагүй болно.

2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүдийн дансны үлдэгдлийг доор үзүүлэв.

	Засгийн газар сая төгрөг	Төрийн Банк сая төгрөг	Хөгжлийн Банк сая төгрөг	ХДК сая төгрөг
2015				
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт	—	—	105,945	—
Засгийн газрын үнэт цаас	202,218	—	—	—
Дотоодын банкуудад олгосон зээл	—	54,972	—	—
Санхүүгийн бус байгууллагуудад олгосон зээл	—	—	—	204,911
Своп хэлцлийн үнэлгээ	—	22	—	—
Бусад хөрөнгө	4,500	20	—	—
Төв банкны үнэт цаас	—	(9,972)	—	—
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	—	(246,178)	(3,048)	—
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	(702,456)	—	—	—
Своп хэлцлийн үнэлгээ	—	(382)	—	—
Бусад өр төлбөр	—	(62)	—	(1,972)
	<u>(495,738)</u>	<u>(201,580)</u>	<u>102,897</u>	<u>202,939</u>

37. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Засгийн газар сая төгрөг	Төрийн Банк сая төгрөг	Хөгжлийн Банк сая төгрөг	ХДК сая төгрөг
2014				
Засгийн газрын үнэт цаас	204,828	—	—	—
Дотоодын банкуудад				
олгосон зээл	—	127,967	—	—
Санхүүгийн бус				
байгууллагуудад				
олгосон зээл	—	—	—	204,911
Своп хэлцлийн үнэлгээ	—	151	—	—
Бусад хөрөнгө	—	31	176,681	—
Төв банкны үнэт цаас	—	(99,836)	—	—
Дотоодын банкуудын				
харилцах, хадгаламж	—	(410,699)	(107,137)	—
Санхүүгийн бус				
байгууллагуудын				
харилцах, хадгаламж	—	—	—	(351)
Засгийн газрын				
байгууллагуудын				
харилцах, хадгаламж	(798,649)	—	—	—
Своп хэлцлийн үнэлгээ	—	(30)	—	—
Бусад өр төлбөр	—	(62)	—	—
	<u>(593,821)</u>	<u>(382,478)</u>	<u>69,544</u>	<u>204,560</u>

2014 болон 2015 онд холбоотой талуудтай хийсэн орлого болон зардлын гүйлгээний дүнг доор харуулав:

	Засгийн газар	Төрийн Банк	Хөгжлийн Банк	ХДК
2015 оны 12 дугаар сарын				
31-ний байдлаар	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Хүүгийн орлого	26,420	4,692	1,407	600
Хүүгийн зардал	(2,618)	(19,570)	—	—
Шимтгэлийн орлого	235	523	2	—
Бусад орлого	—	—	1,944	—
	<u>24,037</u>	<u>(14,355)</u>	<u>3,353</u>	<u>600</u>
2014 оны 12 дугаар сарын				
31-ний байдлаар				
Хүүгийн орлого	373	6,216	—	600
Хүүгийн зардал	(6,537)	(15,758)	—	—
Шимтгэлийн орлого	253	430	5	—
	<u>(5,911)</u>	<u>(9,112)</u>	<u>5</u>	<u>600</u>

37. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурьдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Холбоотой талуудын төлсөн болон хүлээн авсан хүү нь ердийн арилжааны хүүгээр тооцогдсон. Холбоотой талд олгосон зээлээс бусад тайлант жилийн эцсээрх үлдэгдэл дүнгүүд барьцаагаар хангагдаагүй болно. Холбоотой талуудын өглөг эсвэл авлагын дүнд ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

Банкны үндсэн удирдлагын цалин болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор толилуулав.

	2015 сая төгрөг	2014 сая төгрөг
Цалин хөлс	570	539
Тэтгэмжүүд	117	98
Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл	76	70
Бусад олговор	77	392
	<u>840</u>	<u>1,099</u>

38. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Банк нь Төв банк тул дүрмийн сантай холбоотойгоор ямар нэгэн шаардлага бусад этгээдээс тавигддаггүй байна. Төв банк(Монголбанк)-ны тухай хуульд Банкны зайлшгүй байлгах хөрөнгө (дүрмийн сан)-ийн доод хэмжээ болон Банк өөрийн өмчид хуваарилагдах ёстой тухайн жилийн цэвэр ашгийн доод хэмжээг заасан байдаг. Тодруулга 29-д толилуулсны дагуу Банкны дүрмийн сан нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5,000 сая төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5,000 сая төгрөг) байсан нь хуулинд заасан доод хэмжээг хангаж байна. Мөн Банк цэвэр ашгийн 40 хувиас доошгүй хэсэг нь Банк өөрийн хөрөнгийн хэсэгт хуваарилагдаж цэвэр ашгийн үлдэх (цэвэр ашгийн 60%-иас ихгүй) хэсэг нь улсын төсвийн дансанд хуваарилагдана хэмээн дээрх хуульд заажээ. Банк хуримтлагдсан алдагдалтай байгаа тул 2014 болон 2015 онуудад Улсын төсөвт шилжүүлэг хийгээгүй.

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд харуулснаар Банк 2015 онд 473,209 сая төгрөг (2014: 535,473 сая төгрөг)-ийн алдагдал хүлээсэн ба жилийн эцэст өөрийн хөрөнгө 1,428,460 сая төгрөг (2014: 929,794 сая төгрөг)-ийн сөрөг дүнтэй гарсан байна. Банкны өөрийн хөрөнгө 2012 оноос хойш сөрөг дүнтэй байгаа бөгөөд Удирдлага энэ талаар Засгийн газар, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд мэдэгдэх зэрэг хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авсан. Төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 381 дугаар зүйлд “Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэж заасан байдаг.

Тиймээс Засгийн газар Банкны энэхүү дутагдлыг санхүүжүүлэх үүрэг хүлээгээгүй болно. Гэвч Банк үйл ажиллагаагаа хэвийн явуулахад энэхүү болзошгүй хөрөнгийн дутагдлыг арилгах нь зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал энэхүү дутагдлыг арилгах зорилгоор Засгийн газрын бондыг ашиглаж болно.

38. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Энэхүү хуулийн 37 дугаар зүйлд Банкны дахин үнэлгээний сан нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- ▶ Монгол төгрөг болон гадаад валют солилцооны ханшийн хэлбэлзлээс болж алт болон гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө болон өр төлбөрийн валютыг дахин үнэлснээс үүдэлтэй зөрүү;
- ▶ Үндсэн хөрөнгө (байшин, барилга гэх мэт.) -ийн дахин үнэлгээнээс үүдэлтэй зөрүү.

Түүнчлэн мөн хуулийн 37 дугаар зүйлд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө ба өр төлбөр болон алтны дахин үнэлгээнээс үүдэлтэй зөрүүнүүд нь Банкны цэвэр ашгийг тодорхойлоход оруулахгүй гэсэн байна.

Тиймээс Банк үнэт металын, үндсэн хөрөнгийн болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгүүдийн дахин үнэлгээний сангуудыг тус тус байгуулсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 31-ээс харна уу.

39. ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Тодруулга 15-д тусгагдсан Хөгжлийн банкны 55.4 болон 18.8 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй хоёр үнэт цаасыг 2016 оны 2 дугаар сард дотоодын банкуудад 55.4 ба 18.8 тэрбум төгрөгөөр тус тус борлуулсан. Үүний дараа, Банк эдгээр үнэт цаасуудыг барьцаалсан нийт 86.9 тэрбум төгрөгийн, жилийн “бодлогын хүүнээс хасах нь 3%”-ийн хүүтэй, 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр хугацаа нь дуусах урт хугацаат репо санхүүжилтийн гэрээг тэдгээр дотоодын банкуудтай байгуулсан.
- Улсын Их Хурлаас 2016 онд батлагдсан “Ирээдүйн тэтгэврийн нөөц сан”-ийн тухай хуулийн хэрэгжилтийн тухай 12 дугаар тогтоолын дагуу Банк Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай “Хөрөнгө шилжүүлэх гэрээ”-г 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан. Уг гэрээгээр Банк өөрийн дансанд бүртгэлтэй 1,781,345.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ИЗББ болон 678,939 сая төгрөгийн үлдэгдэлтэй дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлүүдийг Засгийн газрын “Ирээдүйн тэтгэврийн нөөц сан”-д хариу төлбөргүйгээр шилжүүлсэн.

Банкны Удирдлага нь тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш энэхүү тайлан гарах өдрийг хүртэл эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөөлөх өөр үйл явдал гараагүй гэж үзэж байна.

40. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.